ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/01/-НА-СТА

2022 он

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч:
Я.Сарансүх

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор:
Ц.Наранчимэг

Аудитын менежер:
Г.Гүнжидмаа
Ц.Хосжаргал

Ахлах аудитор:
Б.Энхжин
Р.Цолмон
А.Даваадорж
Б.Нарангэрэл

Аудитор:
С.Бат-Эрдэнэ
Э.Энхбаатар
Ч.Дашдаваа
Э.Бүгүнүтэй
Г.Мөнхчимэг
Ж.Нямцэцэг
Ж.Мөнхтуул
Н.Нямсүрэн
С.Алтанхуяг

Гэрээт аудитор:
М.Ганбаатар

2022 оны 6 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү:
www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261663 дугаар утсаар харилцана уу.

ХАЯГ:
Үндэсний аудитын газар
Засгийн газрын IV байр,
Бага тойруу-6,
Улаанбаатар-46
Монгол Улс

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ 5
2. АУДИТ ХИЙСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН 7
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН 7
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН ...8
2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН 9
2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН 10
3. АУДИТЫН ТАЙЛАН 12
3.1 АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ 12
3.1.1 Аудит хийсэн үндэслэл 12
3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ 12
3.1.3 Аудитын арга зүй 12
3.1.4 Материаллаг байдлын түвшин 12
3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ 12
3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж 13
3.2.2 Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн 13
3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР ..13
3.3.1 Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан 13
3.3.2 Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан 14
3.3.3 Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 14
3.3.4 Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан 14
4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 14
4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ 14
Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө 15
Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө 16
Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө 16
Төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө 17
4.2 БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 18
4.3 АВЛАГА 18
Төв төрийн сангийн авлага 19
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага 19
Төсөвт байгууллагын авлага 20
Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага 21
Нийгмийн даатгалын сангийн авлага 22
Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага 23
4.4 УРЬДЧИЛГАА 23
4.5 БАРАА МАТЕРИАЛ 24
4.6 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ 24
4.7 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 25
4.8 ҮНДСЭН ХӨРӨНГӨ 26
4.9 ӨР ТӨЛБӨР 27

Үнэт цаас, зээлийн өглөг....28
Төв төрийн сангийн үнэт цаас, зээл....28
Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд....29
Төсөвт байгууллагын өр төлбөр....30
Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөр....31
4.10 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО....31
4.11 ОНЦОЛСОН БОЛОН БУСАД АСУУДАЛ....32
4.11.1 Онцолсон асуудал....32
4.11.2 Бусад асуудал....32
4.11.3 Аудитын гол асуудал....32
4.12 ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....32
Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит....32
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит....33
Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит....33
Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит....34
Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн тайлангийн аудит....35
Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайлангийн аудит....36
4.13 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА....37
4.14 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ....38
4.15 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА....38
5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ....39
5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ....39
5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ....40

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АЗЗА	Авто зам, засвар арчлалт
АХБ	Азийн хөгжлийн банк
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ДТС	Дулаан түгээх сүлжээ
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГСНТ	Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
МУЕП	Монгол Улсын Ерөнхий прокурор
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
МУШС	Монгол Улсын Шадар сайд
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨГ	Орон нутгийн өмчит газар
ОНӨААНБ	Орон нутгийн өмчит, аж ахуйн нэгж байгууллага
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ОСНААУГ	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТОСК	Төрийн орон сууцны корпораци
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨҮҮГ	Төрийн өмчит улсын үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨХЭ	Төрийн өмчит хуулийн этгээд
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техникийн эдийн засгийн үндэслэл
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБЦТС	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УТЕЗ	Улсын төсвийн ерөнхийлөн захирагч
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ҮЦХК	Үнэт цаасны хувьцаат компани
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХК	Хувьцаат компани
ХУД	Хан-Уул дүүрэг
ХҮТ	Хэрэглэгчдэд үйлчлэх төв

ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШС	Шадар сайд
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭТТ	Эрдэнэс Тавантолгой
ЭХЯ	Эрчим хүчний яам

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.06.08 № 1211
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Гадаад зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт зогссон, эзэн холбогдогч тодорхойгүй, олон жил болсон 533.9 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулаагүй;

2. Дамжуулан зээлийн хүүг тооцож, бүртгээгүйгээс 234.8 тэрбум төгрөгийн авлагыг дутуу тайлагнасан;

3. Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн олгосон зээлийн үлдэгдлээс 56.0 хувь буюу 1,793.9 тэрбум төгрөг нь чанаргүй зээлийн ангилалд орсон;

4. Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Чингис хаан банканд байршиж буй 264.3 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөд эрсдэл

Z:\Yawsan_Bichig\2022\0608 Auditiin 2 Gazar-6.Docx

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

үүссэн зэрэг алдаа зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Сангийн яам Монгол Улсын Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Д.ЗАНДАНБАТ

Z:\Yawsan_Bichig\2022\0608 Auditiin 2 Gazar-6.Docx

2. АУДИТ ХИЙСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**22,690,732,864.5**	**22,867,498,936.7**
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,859,650,012.7	4,020,637,362.1
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	896,714,916.4	738,317,077.0
33	АВЛАГА	5,486,456,120.2	5,648,272,396.6
34	УРЬДЧИЛГАА	2,295,599,586.9	3,607,699,378.5
35	БАРАА МАТЕРИАЛ	2,735,207,871.9	2,507,015,580.9
36	НӨӨЦИЙН БАРАА	162,832,743.8	199,845,090.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	6,254,271,612.6	6,145,712,051.5
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**55,861,299,159.8**	**60,255,368,203.6**
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	10,040,403,204.4	10,580,394,035.4
37100	Урт хугацаат хадгаламж	490,969,261.4	449,091,669.4
37200	Үнэт цаас	2,329,124,279.0	2,511,661,507.6
37300	Урт хугацаат зээл	7,220,309,664.0	7,619,640,858.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	45,820,895,955.4	49,674,974,168.2
39100	Газар	277,258,522.0	282,698,309.3
39200	Биет хөрөнгө	22,889,985,235.8	25,792,880,037.5
39300	Биет бус хөрөнгө	17,959,651,023.7	18,024,096,260.7
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	4,694,001,174.0	5,575,299,560.7
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**78,552,032,024.3**	**83,122,867,140.3**
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**	**42,659,815,495.7**	**45,153,212,349.5**
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,203,111,460.0	6,894,084,169.9
41100	Богино хугацаат үнэт цаас	228,045,079.8	15,575,304.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	1,605,983,263.6	1,587,480,057.5
41300	Өглөг	2,280,976,571.4	2,941,513,324.1
41400	Урьдчилж орсон орлого	1,088,106,545.3	2,349,515,484.3
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	37,456,704,035.7	38,259,128,179.6
42100	Урт хугацаат үнэт цаас	14,634,581,288.7	15,094,752,343.4
42200	Урт хугацаат зээл	22,822,122,747.0	23,164,375,836.2
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**35,892,216,528.6**	**37,969,654,790.8**
51	Засгийн газрын хувь оролцоо	35,887,540,372.5	37,964,970,656.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,407,367,350.0	8,496,739,004.3
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	3,528,115,487.0	3,951,074,888.9
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	16,828.6	820.3
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	11,712,874,184.8	11,712,877,184.8
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	7,411,995.5	4,081,890.6
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	7,823,617,390.7	9,354,177,656.7
51200	Хуримтлагдсан үр дүн	-3,976,076,742.3	-3,488,129,134.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,881,593,472.9	7,827,957,192.1
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-12,453,276.5	78,690,171.4
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	486,416,551.2	18,861.1
51600	Нөөцийн сан	28,657,130.6	27,482,120.3
52	Хяналтын бус хувь оролцоо	4,676,156.1	4,684,134.4
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**78,552,032,024.3**	**83,122,867,140.3**

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**19,300,222,111.9**	**24,383,073,703.8**
11	ТАТВАРЫН ОРЛОГО	10,222,077,307.7	13,010,826,650.4
110	Орлогын албан татвар	2,231,573,392.1	3,493,322,519.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	864,737,694.4	1,147,591,192.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-35,616,028.4	-32,777,427.4
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	79,857.7	12,645.3
1103	ААН-ын орлогын албан татвар	1,402,371,868.4	2,378,496,109.2
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	2,487,309,356.5	2,781,121,314.5
113	Хөрөнгийн албан татвар	154,878,633.1	200,974,029.8
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,208,953,720.4	2,837,709,688.7
115	Онцгой албан татвар	776,886,254.3	826,982,908.0
116	Тусгай зориулалтын орлого	17,071,698.5	16,597,696.4
117	Гадаад үйл ажиллагааны орлого	740,742,385.6	975,567,160.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,604,661,867.3	1,878,551,333.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,774,878,987.6	10,568,293,196.0
120	Нийтлэг татварын бус орлого	8,392,878,937.0	9,982,317,828.1
121	Хөрөнгийн орлого	22,316,976.6	2,600,187.3
122	Тусламжийн орлого	359,608,399.2	583,375,180.6
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	74,674.9	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	303,265,816.6	803,953,857.3
II	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**17,096,489,121.8**	**20,901,877,711.5**
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,984,461,858.1	20,876,351,915.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,095,696,709.5	12,300,746,158.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,003,699,028.6	3,229,492,110.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	325,451,292.4	362,808,442.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	315,492,228.5	341,712,897.1
2104	Хангамж, бараа материалын зардал	391,393,729.2	463,705,430.0
2105	Норматив зардал	424,725,868.5	877,349,621.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	98,404,204.1	104,093,792.1
2107	Томилолт, зочны зардал	66,624,034.2	74,402,899.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,222,925,481.6	4,137,339,403.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,246,980,842.4	2,709,841,561.9
211	ХҮҮ	1,653,585,986.3	1,319,357,273.1
212	ТАТААС	308,253,661.6	726,341,252.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,926,925,500.8	6,529,907,232.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	112,027,263.6	25,525,795.8
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)**	**2,203,732,990.1**	**3,481,195,992.3**
IV	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН**	**3,151,280,540.6**	**3,240,830,141.7**
V	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН**	**6,684,236,702.2**	**5,084,781,355.9**
VI	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)**	**-1,329,223,171.5**	**1,637,244,778.1**

2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**34,021,776,833.7**	**-**	**34,021,776,833.7**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-96,894,240.1	-	-96,894,240.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,924,882,593.6	-	33,924,882,593.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	817,515,343.2	-	817,515,343.2
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-108,607,043.6	-	-108,607,043.6
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	7,265,610.9	-	7,265,610.9
Өмчид гарсан өөрчлөлт	3,867,413,792.6	-	3,867,413,792.6
Зарласан ногдол ашиг	-1,287,030,596.4	-	-1,287,030,596.4
Тайлант үеийн үр дүн	-1,329,223,171.5	-	-1,329,223,171.5
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,892,216,528.6	-	35,892,216,528.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-466,510,831.9	-	-466,510,831.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,425,705,696.7	-	35,425,705,696.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	21,493,696.7	-	21,493,696.7
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	32,985,383.4	-	32,985,383.4
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	61,473,571.7	-	61,473,571.7
Өмчид гарсан өөрчлөлт	1,025,322,162.7	-	1,025,322,162.7
Зарласан ногдол ашиг	-234,570,498.6	-	-234,570,498.6
Тайлант үеийн үр дүн	1,637,244,778.1	-	1,637,244,778.1
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,969,654,790.8	-	37,969,654,790.8

2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)**	**24,765,288,606.8**	**28,685,195,037.7**
11	ТАТВАРЫН ОРЛОГО	9,914,142,480.5	13,259,633,083.6
110	Орлогын албан татвар	2,500,114,846.2	3,363,617,357.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	864,360,148.0	1,147,288,772.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-35,616,028.4	-32,777,427.4
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	79,857.7	12,645.3
1103	ААН-ын орлогын албан татвар	1,671,290,868.9	2,249,093,366.8
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	1,785,430,003.9	2,549,771,585.6
113	Хөрөнгийн албан татвар	154,878,633.1	201,104,015.5
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,210,894,395.0	2,907,503,962.7
115	Онцгой албан татвар	776,900,367.6	867,459,234.1
116	Тусгай зориулалтын орлого	16,371,698.5	16,597,696.4
117	Гадаад үйл ажиллагааны орлого	738,837,953.7	943,391,019.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,730,714,582.6	2,410,188,212.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,542,899,180.0	2,183,587,631.4
1181	Газрын төлбөр	118,277,141.7	141,334,948.5
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	64,272,180.6	78,244,355.2
1183	Бусад татвар	5,266,080.3	7,021,277.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,365,363,119.4	14,356,233,531.1
120	Нийтлэг татварын бус орлого	14,235,321,162.8	13,991,170,496.0
121	Хөрөнгийн орлого	22,330,276.6	2,721,812.5
122	Тусламжийн орлого	107,446,721.7	362,020,302.2
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	264,958.3	320,920.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	485,783,006.9	1,069,328,423.0
II	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**21,124,704,953.7**	**24,915,334,302.7**
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,124,704,953.7	24,915,334,302.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,737,460,709.0	16,209,487,337.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,882,349,904.8	4,174,783,378.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	548,774,964.5	630,823,354.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	625,349,388.7	659,441,658.8
2104	Хангамж, бараа материалын зардал	2,366,933,259.6	2,756,697,496.0
2105	Норматив зардал	378,023,348.0	575,328,108.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	124,041,708.4	123,704,212.3
2107	Томилолт, зочны зардал	81,029,281.6	78,281,129.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,744,711,712.6	6,389,690,771.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	986,247,141.0	820,737,227.7
211	ХҮҮ	1,344,996,216.2	1,187,298,390.0
212	ТАТААС	323,594,755.2	532,092,055.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,718,653,273.3	6,986,456,520.1
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)**	**3,640,583,653.1**	**3,769,860,735.0**
IV	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)**	**213,437,309.1**	**389,826,404.4**
V	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)**	**4,418,717,456.5**	**4,461,141,703.0**
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,418,717,456.5	4,461,141,703.0
2200	Дотоод эх үүсвэрээр	4,418,717,456.5	4,461,141,703.0

VI	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)**	**-4,205,280,147.4**	**-4,071,315,298.6**
VII	**САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН**	**-724,597,833.4**	**-537,558,087.0**
14	Бусад эх үүсвэр	1,272,004,504.6	2,411,309,652.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	146,787,817.1	44,073,274.2
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	960,317,266.3	1,012,067,555.2
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	889,497,254.6	1,892,726,909.7
VIII	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)**	**-1,289,294,327.7**	**-839,012,650.6**
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,148,944,340.3	4,859,650,012.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,859,650,012.7	4,020,637,362.1

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

3.1.1 Аудит хийсэн үндэслэл

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, УСНББОУС, СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгуудыг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын горим юм.

Төрийн аудитын байгууллага нь Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

3.1.3 Аудитын арга зүй

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, үнэлгээ өгөв.

3.1.4 Материаллаг байдлын түвшин

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, төсөл, хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайлангууд нэгтгэгддэг тул материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үе шатанд Засгийн газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 23,780.7 тэрбум төгрөгийн 1.0 хувь буюу 237.8 тэрбум төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх заалтын дагуу Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн, хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагч хоорондын тооцоогоор баталгаажуулсан өр төлбөр, авлага, ажил гүйлгээний давхардсан 10,190.7 тэрбум төгрөгийг санхүүгийн байдлын тайланд, 28,953.8 тэрбум төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд, 35,118.4 тэрбум төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тус тус устгал хийсэн;
- Төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан байна.

Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 57 ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэдгээрийн харьяа 4674 төсөвт байгууллага, 604 төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээд, 371 төрийн сан, 1383 төсөл сан нийт 7032 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр, санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулга тайланг мянган төгрөгөөр илэрхийлжээ.

3.2.2 Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны “Э-тайлан” программаар нэгтгэн гаргасан ба дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:

А. Үндсэн тайлан	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим 3-21 дүгээр тодруулгууд
Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	1а, 1б, 2а, 2б тодруулга
Засгийн газрын нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
Засгийн газрын нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	

3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

3.3.1 Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 83,122.9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 5.8 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт №1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч /сая төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Дүнд эзлэх хувь	
			Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Эргэлтийн хөрөнгийн дүн	22,690,732.9	22,867,498.9	28.9	27.5
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	55,861,299.1	60,255,368.2	71.1	72.5
Нийт хөрөнгийн дүн	**78,552,032.0**	**83,122,867.1**	**100.0**	**100.0**
Нийт өр төлбөр	42,659,815.5	45,153,212.3	54.3	54.3
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	35,892,216.5	37,969,654.8	45.7	45.7
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**78,552,032.0**	**83,122,867.1**	**100.0**	**100.0**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгө өмнөх оноос 4,570.9 тэрбум төгрөгөөр өсөхөд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хөрөнгө 1,182.6 тэрбум, Ирээдүйн өв сангийн хөрөнгө 1,010.9 тэрбум, Тавантолгой төмөр зам ХХК-ийн хөрөнгө 899.3 тэрбум, Төрийн худалдан авах ажиллагааны газрын хөрөнгө 615.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

3.3.2 Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 1,637.2 тэрбум төгрөгийн эерэг үзүүлэлттэй тайлагнасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нийт 1,150.7 тэрбум төгрөгийн ашигтай, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүн 1,496.1 тэрбум, төсөл сангийн үйл ажиллагааны үр дүн 1,035.5 тэрбум төгрөгийн тус тус эерэг */орлого нь зардлаасаа их/* үзүүлэлттэй, төрийн сангийн үйл ажиллагааны нийт үр дүн 2,045.1 тэрбум төгрөгийн сөрөг */зардал нь орлогоосоо их/* үзүүлэлттэй гарсан байна.

3.3.3 Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Засгийн газрын 2021 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаар Засгийн газрын хувь оролцоо 2,087.5 тэрбум төгрөгөөр өссөн нь харьяа байгууллагуудын тайлант үеийн үр дүн нэмэгдсэн болон Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын өмч 3,239.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.3.4 Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Засгийн газрын 2021 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангаар мөнгөн орлого 31,486.3 тэрбум, зарлага 32,325.3 тэрбум, цэвэр мөнгөн гүйлгээ 839.0 тэрбум төгрөгийн сөрөг үзүүлэлттэй илэрхийлэгдсэн байна.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,859.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,020.6 тэрбум төгрөг болж, 839.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	56,028.3	47,286.5	-8,741.8	1.2
Банканд байгаа бэлэн мөнгө	4,231,333.7	3,672,920.5	-558,413.2	91.4
Замд яваа мөнгөн хөрөнгө	59,268.2	61,515.2	2,247.0	1.5
Хадгаламж	513,019.8	238,915.1	-274,104.7	5.9
Дүн	**4,859,650.0**	**4,020,637.3**	**-839,012.7**	**100.0**
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	187,958.4	246,605.5	58,647.1	6.1
Төсөл/ сан	2,162,255.9	996,494.3	-1,165,761.6	24.8
Төрийн сан	524,545.5	719,351.8	194,806.3	17.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,984,890.2	2,058,185.7	73,295.5	51.2
Дүн	**4,859,650.0**	**4,020,637.3**	**-839,012.7**	**100.0**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 839.0 тэрбум төгрөгөөр буурахад дараах ажил, гүйлгээнүүд голлон нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд 195.0 тэрбум төгрөгийг зарцуулсан;
- Эрдэнэс Тавантолгой ХК болон Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Чингис хаан банкан дахь 54.9 тэрбум, Үндэсний хөрөнгө оруулалтын банкан дахь 70.6 тэрбум төгрөгийн харилцах дансдын үлдэгдлийг авлагаар бүртгэсэн;
- Эрдэнэс Силвер Ресурс ХХК-ийн Худалдаа хөгжлийн банкан дахь 34.5 тэрбум төгрөгийн хадгаламжийг хааж, бондын төлбөр төлсөн;
- ИНЕГ үндсэн үйл ажиллагааны орлого буурсантай холбоотойгоор мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 60.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Банкан дахь харилцах дансны 3,672.9 тэрбум төгрөгөөс гадаад валютын үлдэгдэл 967.4 тэрбум төгрөг байна. Үүнээс 248.9 тэрбум төгрөг нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 591.0 тэрбум төгрөг нь төрийн сан, 98.2 тэрбум төгрөг нь төсөл сан, 29.3 тэрбум төгрөг нь төсөвт байгууллагын үлдэгдэл байна.

Арилжааны банкан дахь нийт 1,954.8 тэрбум төгрөгийн 46.9 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 45.1 хувийг төсөл сан, 6.8 хувийг төсөвт байгууллага, 1.2 хувийг төрийн сангийн үлдэгдэл эзэлж байна.

Хүснэгт №3. Хадгаламж дахь мөнгөн хөрөнгө */сая төгрөг/*

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Эрүүл мэндийн даатгалын сан	350,000.0	100,000.0	-250,000.0	41.9
Зээлийн батлан даалтын сан	68,196.2	85,405.2	17,209.0	35.7
Монгол Улсын Их сургууль	28,413.1	22,635.4	-5,777.7	9.5
Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургууль	5,199.5	8,056.5	2,857.0	3.4
Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	18,155.2	6,515.7	-11,639.5	2.7
Монгол Улсын Боловсролын Их сургууль	6,690.6	6,097.9	-592.7	2.6
Монголын цахилгаан холбоо ХК	3,694.7	3,430.4	-264.3	1.4
Шинжлэх Ухаан Технологийн Их сургууль	2,108.8	3,108.8	1,000.0	1.3
Монгол шуудан ХК	3,600.0	3,000.0	-600.0	1.2
Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль	660.1	615.1	-45.0	0.3
Ховд Их Сургууль	800.0	28.0	-772.0	-
Гүний ус ХХК	10.6	22.1	11.5	-
Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	15,491.0	-	-15,491.0	-
Нийгмийн даатгалын ерөнхий газар	10,000.0	-	-10,000.0	-
Дүн	**513,019.8**	**238,915.1**	**-274,104.7**	**100.0**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хадгаламж дахь мөнгөн хөрөнгө 274.1 тэрбум төгрөгөөр буурахад Эрүүл мэндийн даатгалын сан 2021 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор хадгаламжаас 250.0 тэрбум төгрөгийг татсан нь голлон нөлөөлсөн байна.

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 493.5 тэрбум, эцсийн үлдэгдэл 671.3 тэрбум болж, 177.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт(-)
Банканд байгаа мөнгөн хөрөнгө	466,820.8	625,851.2	159,030.4
Төгрөг	43,457.0	52,688.7	9,231.7
Төрийн сан	33,837.8	38,471.7	4,633.9
Монголбанк	8,858.6	8,863.3	4.7
Арилжааны банк	760.6	5,353.7	4,593.1
Гадаад валют	423,363.8	573,162.5	149,798.7
Монголбанк	423,363.8	573,162.5	149,798.7
Замд яваа мөнгөн хөрөнгө	26,727.3	45,458.1	18,730.8
Дүн	**493,548.1**	**671,309.3**	**177,761.2**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 7.8 хувийг төгрөгийн харилцах, 85.4 хувийг гадаад валютын харилцах, 6.8 хувийг замд яваа мөнгөн хөрөнгө эзэлж байна.

Мөнгөн хөрөнгө үйл ажиллагааны орлогоос 10,223.0 тэрбум, зээлийн эргэн төлөлтөөс 75.0 тэрбум, зээлийн эх үүсвэрээс 4,108.6 тэрбум, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз 30.1 тэрбум, нийт 14,436.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, урсгал зардалд 9,853.8 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 1,578.1 тэрбум, зээлийн эргэн төлөлт, ханшийн зөрүүнд 2,827.1 тэрбум, нийт 14,259.0 тэрбум төгрөгийн зардлаар хасагдсан байна.

Төв төрийн сан улсын төсвийн зарлагын эх үүсвэрийн дутагдал 4,108.6 тэрбум төгрөгийг төрийн сангийн нэгдсэн дансанд төвлөрсөн мөнгөн хөрөнгөөс санхүүжүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 732.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 905.5 тэрбум болж, 173.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	722,313.6	905,507.3	183,193.7	100.0
Төрийн сангийн харилцах	16,987.8	299,904.7	282,916.9	33.1
Нэмэлт санхүүжилт	45.8	22.1	-23.7	0.0
Арилжааны банкны харилцах	705,280.0	605,580.5	-99,699.5	66.9
Хадгаламж	10,000.0	-	-10,000.0	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	59.6	34.7	-24.9	0.0
Дүн	**732,373.2**	**905,542.0**	**173,168.8**	**100.0**
Үүнээс, сангийн төрлөөр				
Тэтгэврийн даатгалын сангийн харилцах	249,115.2	573,432.6	324,317.4	63.3
Тэтгэмжийн даатгалын сангийн харилцах	40,662.7	59,442.6	18,779.9	6.6
ҮОМШӨ-ний даатгалын сангийн харилцах	380,753.7	201,803.6	-178,950.1	22.3
Ажилгүйдлийн даатгалын сангийн харилцах	42,614.6	59,015.2	16,400.6	6.5
Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах	9,467.7	7,307.2	-2,160.5	0.8
Төвлөрсөн харилцах	9,336.3	4,457.0	-4,879.3	0.5
Үйл ажиллагааны харилцах	363.4	49.1	-314.3	0.0
Замд яваа мөнгө	59.6	34.7	-24.9	0.0
Дүн	**732,373.2**	**905,542.0**	**173,168.8**	**100.0**

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2020 оны 140 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам"-ын дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн "2020 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай" 2020 оны 09 дүгээр тогтоол, 2021 оны төсвийн хуваарь батлах тухай" 2020 оны 10 дугаар тогтоолоор ҮОМШӨ даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд 2020 онд 435.4 тэрбум, 2021 онд 271.2 тэрбум, нийт 706.6 тэрбум төгрөгийг шилжүүлэн зарцуулсан байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос өссөн нь дээрх журмын хэрэгжилт 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөр дуусвар болж, албан журмын болон сайн дурын даатгуулагчид нийгмийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын тухай хуульд заасан хувь хэмжээгээр төлж эхэлсэнтэй холбоотой байна.

Тээвэр хөгжлийн банкан дахь 10.0 тэрбум төгрөгийн хадгаламжийн хугацаа дуусаж, мөнгөн хөрөнгийг харилцах данс руу шилжүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 617.2 тэрбум, эцсийн үлдэгдэл 422.2 тэрбум болж, 195.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	108,695.3	161,659.2	52,963.9	38.3
Арилжааны банкан дахь харилцах	158,560.9	156,742.8	-1,818.1	37.1
Бусад төсөл, нөөцийн харилцах	0.0	3,422.2	3,422.2	0.8
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.0	393.1	393.1	0.1
Хадгаламж	350,000.0	100,000.0	-250,000.0	23.7
ДҮН	**617,256.2**	**422,217.3**	**-195,038.9**	**100.0**

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн алдагдлыг сангийн чөлөөт үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Өмнөх онд эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангаас 9.6 тэрбум төгрөгийг "16 аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж"-ийг худалдан авахад зарцуулахаар нэмэлт санхүүжилтийн дансанд байршуулсан боловч тус төлбөрийг тайлант оны төсвөөс зарцуулсан;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны "Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулах тухай" 02 дугаар тогтоолд эрсдэлийн санг 2021 оны нийт орлогын 8 хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулахаар заасныг хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,142.0 тэрбум, эцсийн үлдэгдэл 2,482.9 тэрбум болж, 659.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7. Улс, орон нутгийн ТЕЗ-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	56,028.3	47,286.5	-8,741.8	1.9
Банканд байгаа бэлэн мөнгө	2,900,496.9	2,280,691.0	-619,805.9	91.8
Замд яваа мөнгөн хөрөнгө	32,481.3	16,022.4	-16,458.9	0.7
Хадгаламж	153,019.8	138,915.1	-14,104.7	5.6
Дүн	**3,142,026.3**	**2,482,915.0**	**-659,111.3**	**100.0**
Үүнээс, ТЕЗ-ийн төрлөөр				
ОНТЕЗ	281,769.9	332,352.8	50,582.9	13.4
УТЕЗ	2,860,256.4	2,150,562.2	-709,694.2	86.6
Дүн	**3,142,026.3**	**2,482,915.0**	**-659,111.3**	**100.0**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 2019 оны 430, 2020 оны 253, 2021 оны 397 дугаар тогтоолын дагуу хэрэгжээгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт 378.4 тэрбум төгрөгийг 17 Төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,860.2 тэрбум, эцсийн үлдэгдэл 2,150.5 тэрбум төгрөг болж, 709.7 тэрбум төгрөгөөр буурсан ба үлдэгдлийн 91.2 хувийг харилцах данс, 6.5 хувийг хадгаламж, 2.2 хувийг касст байгаа бэлэн мөнгө, 0.1 хувийг замд яваа мөнгөн хөрөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг, техник хяналтын зардлаас хэмнэсэн хөрөнгө, тэмдэгтийн хураамж, түрээсийн орлого, хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл, дэнчин, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 4.4 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй /ХХААХҮЯ 2.5 тэрбум, ЭХЯ 0.7 тэрбум, ШЕЗ 0.4 тэрбум, ЗТХЯ 0.4 тэрбум, ЗГХЭГ 0.2 тэрбум, БХБЯ 0.1 тэрбум, бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/;
- Мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг зөрчсөн, мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй илэрхийлсэн, кассын үлдэгдлийг төвлөрүүлээгүй, зарлагын гүйлгээ хийх дээд хязгаарыг хэтрүүлсэн ЭХЯ 0.1 тэрбум төгрөг;
- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 16.7 тэрбум төгрөг /ЭМЯ 3.9 тэрбум, БШУЯ 3.0 тэрбум, МУШС 2.8 тэрбум, ХХААХҮЯ 1.5 тэрбум, ХЗДХЯ 1.2 тэрбум, ХНХЯ 0.7 тэрбум, ЗТХЯ 0.6 тэрбум, ЭХЯ 0.4 тэрбум, ШЕЗ 0.3 тэрбум, МУЕП 0.2 тэрбум, УУХҮЯ 0.2 тэрбум, бусад ТЕЗ 1.9 тэрбум төгрөг/.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 281.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 332.3 тэрбум төгрөг болж, 50.6 тэрбум төгрөгөөр өссөн ба үлдэгдлийн 95.4 хувийг банкан дахь харилцах, 4.4 хувийг замд яваа, 0.2 хувийг кассад байгаа мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл эзэлж байна.
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 203.0 тэрбум, Төрийн сан 48.0 тэрбум, төсөвт байгууллага 58.4 тэрбум, төсөл сангууд 22.9 тэрбум, нийт 332.3 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчиж худалдан авалт хийсэн, гэрээний зүйл, заалтыг мөрдөөгүй 0.6 тэрбум төгрөг /Сэлэнгэ 0.2 тэрбум, Ховд 0.2 тэрбум, Сүхбаатар 0.1 тэрбум, бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/;
- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 4.4 тэрбум төгрөг /Нийслэл 1.5 тэрбум, Орхон 1.1 тэрбум, Говь-Алтай 0.9 тэрбум, Ховд 0.3 тэрбум, Хөвсгөл 0.3 тэрбум, Хэнтий 0.2 тэрбум, бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/;
- Мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг зөрчсөн, мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй илэрхийлсэн, байгууллагын эд хариуцагчийн дансаар бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн, кассын зарлагын гүйлгээ хийх дээд хязгаарыг хэтрүүлсэн 0.6 тэрбум төгрөг /Өмнөговь 0.2 тэрбум, Төв 0.1 тэрбум, Өвөрхангай 0.1 тэрбум, бусад ТЕЗ 0.2 тэрбум төгрөг/;
- Орон нутгийн төсөвт төвлөрүүлбэл зохих түрээсийн орлого, төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй 0.4 тэрбум төгрөг /Хэнтий 0.2 тэрбум, Хөвсгөл 0.1 тэрбум, бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/.

4.2 БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 896.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 738.3 тэрбум төгрөг болж, 158.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №8. Богино хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагаар */сая төгрөг/*

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн банк ХХК	887,904.5	737,541.7	-150,362.8	99.9
МИАТ ТӨХК	7,961.7	-	-7,961.7	-
Боловсролын зээлийн сан	848.7	575.3	-273.4	0.1
Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ХК	-	200.0	200.0	0.0
Дүн	**896,714.9**	**738,317.0**	**-158,397.9**	**100.0**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны бууралтад Төрийн банк ХХК-ийн Монголбанкан дахь богино хугацаат үнэт цаасны хугацаа дуусаж, 150.4 тэрбум төгрөг төлсөн, МИАТ ТӨХК Голомт банкан дахь хадгаламж 7.9 тэрбум төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан нь нөлөөлжээ.

Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК нь 0.2 тэрбум төгрөгийн богино хугацаат хөрөнгө оруулалт хийсэн байна.

4.3 АВЛАГА

Авлага дансны эхний үлдэгдэл 5,486.5 тэрбум, эцсийн үлдэгдэл 5,648.3 тэрбум болж, 161.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9. Авлага дансны ангилал, байгууллагын төрлөөр */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагсадтай холбогдсон авлага	3,217.6	3,369.7	152.1	0.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	314,486.9	406,658.4	92,171.5	7.2
Татаас, санхүүжилтийн авлага	719,717.6	678,307.2	-41,410.4	12.0

Зээлийн хүүгийн авлага	322,546.4	299,921.9	-22,624.5	5.3
Дансны авлага /ТӨҮГ/	450,036.0	468,038.0	18,002.0	8.3
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	164,327.7	197,236.4	32,908.7	3.5
Бусад авлага	1,252,302.1	1,310,957.5	58,655.4	23.2
Зээлийн авлага	2,259,821.8	2,283,783.3	23,961.5	40.4
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	1,304,691.5	1,227,392.7	-77,298.8	21.7
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн авлага	955,130.3	1,056,390.6	101,260.3	18.7
Дүн	**5,486,456.1**	**5,648,272.4**	**161,816.3**	**100.0**
Үүнээс, байгууллагын төрлөөр				
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,644,495.3	1,781,443.0	136,947.7	31.5
Төрийн сан	1,207,546.6	1,246,686.0	39,139.4	22.1
Төсөвт байгууллага	1,143,190.2	1,153,003.8	9,813.6	20.4
Төсөл/Сан	1,491,224.0	1,467,139.6	-24,084.4	26.0
Дүн	**5,486,456.1**	**5,648,272.4**	**161,816.3**	**100.0**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны 40.4 хувийг зээлийн, 23.2 хувийг бусад, 12.0 хувийг татаас, санхүүжилтийн, 8.3 хувийг ТӨҮГ-ын дансны, 7.2 хувийг төлбөртэй үйлчилгээний, 8.9 хувийг бусад төрлийн авлага эзэлж байна.

Авлагын өсөлтөд дамжуулан зээл 101.3 тэрбум, төлбөртэй үйлчилгээ 92.2 тэрбум, бусад 58.6 тэрбум төгрөгийн авлага нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Төв төрийн сангийн авлага

Төв төрийн сангийн авлагын эхний үлдэгдэл 1,202.2 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,239.8 тэрбум төгрөг болж, 37.6 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд нийт авлагын 83.8 хувь буюу 1,038.8 тэрбум төгрөгийг дамжуулан зээлийн авлага эзэлж байна.

Хүснэгт №10. Төв төрийн сангийн авлага /сая төгрөг/

Харилцагч байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	4,011.8	2,668.9	-1,342.9
Бусад авлага	238,238.4	190,423.0	-47,815.4
Зээлийн авлага	959,946.0	1,046,730.7	86,784.7
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	19,821.9	7,921.7	-11,900.2
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн авлага	940,124.1	1,038,809.0	98,684.9
Дүн	**1,202,196.2**	**1,239,822.6**	**37,626.4**

Эх сурвалж: Төв төрийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан

Зээлийн хүүгийн авлагын бууралт нь 1.3 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн эргэн төлөлт хийсэнтэй холбоотой байна.

Бусад авлага Монголбанканд олгосон ипотекийн санхүүжилтээс 67.1 тэрбум, Төрийн банканд олгосон орон сууцны хөтөлбөрийн санхүүжилтээс 45.8 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийсэн дүнгээр буурч, Гаалийн ерөнхий газрын байгууллагаас авах авлага 36.6 тэрбум, Монгол Улсад /Ковид-19/ халдвараас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах бэлэн байдлыг хангах төслөөс авах 26.5 тэрбум төгрөгийн авлага нэмэгдсэн.

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын эхний үлдэгдэл 940.1 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,038.8 тэрбум төгрөг болж, 98.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №11. Төв төрийн сангийн гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн авлага /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
ЗГ-ын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	413,052.2	407,178.4	-5,873.8
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон	15,732.8	123,849.1	108,116.3
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон	511,339.1	507,781.5	-3,557.6
Дүн	**940,124.1**	**1,038,809.0**	**98,684.9**

Эх сурвалж: Төв төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын 48.9 хувийг хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүдэд олгосон зээл, 39.2 хувийг Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээл, 11.9 хувийг төрийн өмчит аж ахуй нэгжүүдэд олгосон зээл эзэлж байна.

Тайлант онд дамжуулан зээлийн ашиглалт 267.6 тэрбум төгрөг гарснаас, 178.8 тэрбум төгрөгийн Дэлхийн банкны 1, Азийн хөгжлийн банкны 3, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын 2, Бүгд Найрамдах Беларусь Улсын Хөгжлийн банкны 1, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны 2, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн 1 төсөл шинээр хэрэгжиж эхэлсэн, өмнөх онуудад эхэлсэн 18 төсөл хэрэгжиж дуусан байна.

Дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн төлбөрт 65.7 тэрбум, зээлийн хүүгийн төлбөрт 31.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Дамжуулан зээлийг 11 донор байгууллагаас 7 төрлийн валютаар авч дотоодын аж ахуй нэгж, байгууллагад дамжуулан зээлдүүлсэн бөгөөд тайлант онд 84.9 тэрбум төгрөгийн ханшийн зөрүүний алдагдал хүлээсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Дамжуулан зээлийн хүүг тооцож, бүртгээгүйгээс 234.8 тэрбум төгрөгийн авлагыг дутуу тайлагнасан;
- Гадаад зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдэд дамжуулан зээлдүүлсэн зээлийн хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй 301.3 тэрбум төгрөгийн зээлийг барагдуулах арга хэмжээ хангалтгүй;
- “Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл”-ийн хүрээнд 2011 онд дамжуулан зээлдүүлсэн 200.8 тэрбум, Налайх-Чойр чиглэлийн 220 км автозам, Дархан-Эрдэнэт чиглэлийн автозамтай холбоотой дамжуулан зээлийн 101.2 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, холбогдох байгууллагуудын санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгээгүй;
- Хувийн хэвшлийн 89 аж ахуй нэгжид 1991-1996 онуудад дамжуулан зээлийн гэрээгээр олгосон 232.6 тэрбум төгрөгийн авлагаас шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болсон авлагыг шийдвэрлэх, эзэн холбогдогч нь тодорхой авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна.

Төсөвт байгууллагын авлага

Төсөвт байгууллагуудын авлагын дансны эхний үлдэгдэл 1,143.2 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,153.0 тэрбум болж, 9.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №12. Төсөвт байгууллагын авлага */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Орон нутаг	140,539.9	138,342.1	-2,197.8
Улсын төсөв	1,002,650.3	1,014,661.7	12,011.4
Дүн	**1,143,190.2**	**1,153,003.8**	**9,813.6**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын нийт авлагын 88.0 хувь нь улсын төсвийн, 12.0 хувь нь орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын авлага байна.

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын авлагын үлдэгдэлд ХХААХҮЯ 32.9 хувийг, БШУЯ 26.4 хувийг, Сангийн яам 11.0 хувийг, ЭМЯ 8.1 хувийг, ХНХЯ 7.6 хувийг, ХЗДХЯ 7.5 хувийг, бусад УТЕЗ 6.5 хувийг тус тус эзэлж байна.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын авлагын үлдэгдэлд Нийслэл 26.5 хувийг, Өмнөговь 8.5 хувийг, Төв 6.4 хувийг, Ховд 5.5 хувийг, Архангай 4.6 хувийг, Өвөрхангай 4.5 хувийг, Хэнтий 4.4 хувийг, бусад ОНТЕЗ 35.6 хувийг тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлагыг зөрүүтэй тайлагнасан, бүртгэлд тусгаагүй, тайлагнаагүй 7.0 тэрбум төгрөг /ОНТЕЗ 3.6 тэрбум, БШУЯ 2.6 тэрбум, ЭХЯ 0.6 тэрбум, ЭМЯ 0.1 тэрбум, бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/;
- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж, баталгаажуулаагүй 29.9 тэрбум төгрөг /ОНТЕЗ 14.1 тэрбум, ХХААХҮЯ 5.6 тэрбум, ЗТХЯ 5.4 тэрбум, ЭХЯ 1.2 тэрбум, ЗГХЭГ 1.1 тэрбум, УУХҮЯ 0.7 тэрбум, БШУЯ 0.5 тэрбум, ХНХЯ 0.5 тэрбум, ХЗДХЯ 0.3 тэрбум, ШС 0.2 тэрбум, бусад ТЕЗ 0.3 тэрбум төгрөг/;
- Төсвийг зохисгүй удирдаж авлага үүсгэсэн 18.6 тэрбум төгрөг /ЭМЯ 12.3 тэрбум, ОНТЕЗ 4.5 тэрбум, ГХЯ 1.2 тэрбум, БОАЖЯ 0.4 тэрбум, ХЗДХЯ 0.1 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/;
- Хугацаа хэтэрсэн болон олон жилийн насжилттай, эзэн холбогдогчгүй болж найдваргүй болох эрсдэлтэй авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй 259.8 тэрбум төгрөг /ХХААХҮЯ 210.2 тэрбум, ОНТЕЗ 23.6 тэрбум, ХНХЯ 15.0 тэрбум, ШС 5.9 тэрбум, ЭМЯ 3.3 тэрбум, ЗТХЯ 0.8 тэрбум, ЭХЯ 0.6 тэрбум, ХЗДХЯ 0.2 тэрбум төгрөг, бусад ТЕЗ 0.2 тэрбум төгрөг/.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлагын эхний үлдэгдэл 1,644.5 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,781.4 тэрбум болж, 136.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №13. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага */сая төгрөг/*

Өмчийн хэлбэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Орон нутгийн өмчит хуулийн этгээд	224,057.0	321,916.4	97,859.4
Төрийн өмчит хуулийн этгээд	1,420,438.3	1,459,526.6	39,088.3
Дүн	**1,644,495.3**	**1,781,443.0**	**136,947.7**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн өмчит хуулийн этгээдийн авлагын үлдэгдэлд Монгол Улсын Хөгжлийн банк ХХК 38.1 хувийг, Төрийн орон сууцны корпораци ТӨХК 10.9 хувийг, Зээлийн батлан даалтын сан 7.7 хувийг Тавантолгой төмөр зам ХХК 7.4 хувийг, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК 5.3 хувийг, бусад төрийн өмчит хуулийн этгээд 30.6 хувийг тус тус эзэлж байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн авлагын өсөлтөд Зээлийн батлан даалтын сан 112.4 тэрбум, Тавантолгой төмөр зам ХХК 70.1 тэрбум, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК 22.7 тэрбумаар өссөн нь голлон нөлөөлжээ.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлагын үлдэгдэлд Нийслэлийн орон сууцны корпораци ХК 55.7 хувийг, Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ 7.4 хувийг, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ 7.4 хувийг, Тавантолгой ХК 5.8 хувийг, Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ ОНӨХК 4.9 хувийг, бусад ОНӨААНБ 18.8 хувийг тус тус эзэлж байна.

Авлагын өсөлтөд Нийслэлийн орон сууцны корпораци ХК-ийн иргэдээс авах 61.9 тэрбум, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ-ын байгууллагуудаас авах 17.8 тэрбум төгрөгийн авлага нэмэгдсэн зэрэг нь голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

- Зээлийн батлан даалтын сангийн удирдах зөвлөлийн 2020 оны 24 дүгээр тогтоолын дагуу 2.2 тэрбум төгрөгийн 476 м2 оффисын барилгыг Чингис хаан банк ХХК-ийн авлагад тооцон худалдан авсан боловч үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гараагүй, өөрийн өмчлөлд шилжүүлээгүй зөрчилд өмнөх аудитаар албан шаардлага хүргүүлсэн ба тайлант оны эцэст дээрх үл хөдлөх хөрөнгө нь өмчлөлд шилжин ирээгүй, шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй, зөрчил арилаагүй;
- Зээлийн батлан даалтын сангийн өмнөх онд өндөр эрсдэлтэй гэж үнэлсэн 0.8 тэрбум төгрөгийн зээлд батлан даалт гаргасан нь тухайн жилдээ чанаргүй зээлийн ангилалд бүртгэгдэж, 2021 онд муу зээлийн ангилалд орсон;
- УБЦТС ТӨХК 2018 онд үүссэн 0.4 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулаагүй;

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

- Монгол Улсын Хөгжлийн банк ХХК нь нийт 2,159.6 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд эдгээрээс экспортыг дэмжсэн нийт 54 төсөл, хөтөлбөрийн зээлийн дүн нийт зээлийн багцын 58.4 хувийг эзэлж байна
- Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн нийт санхүүжүүлсэн зээлээс 56.0 хувь буюу 1,793.9 тэрбум төгрөг нь чанаргүй зээлийн ангилалд орж, зээл эргэн төлөгдөхгүй байх эрсдэлд орсон;
- Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-аас Төрийн орон сууцны корпораци ТӨХК-д олгосон зээлийн хүрээнд Засгийн газрын 2018 оны 81 дүгээр тогтоол, 2019 оны 233 дугаар тогтоол болон ТУЗ-ийн холбогдох тушаалд заасны дагуу Нийслэл, Хөвсгөл, Говь-Алтай, Орхон аймгийн Засаг дарга нартай нийт 109.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий орон сууцны барилгуудыг 5 жилийн хугацаанд, жилийн 6.0 хувийн хүүтэй нөхцөлөөр худалдан борлуулж, Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-д эргүүлэн төлөх нөхцөлтэй байгуулсан гэрээнд заасан хуваарийн дагуу зээлийг эргэн төлөх үүргээ биелүүлээгүйгээс нийт 21.5 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, хүү, алданги хуримтлагдсан, 4.5 тэрбум төгрөгийн зээлийн хүү, алдангийг санхүүгийн тайланд авлагаар хүлээн зөвшөөрөөгүй;
- Монгол Улсын Хөгжлийн банк ХХК 12.7 тэрбум төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-аас 2017 онд Эгийн голын усан цахилгаан станц ТӨХК -д 10.6 сая ам.долларын зээлийг хэсэгчлэн олгосон ба зээлийн хугацаа 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болж зээл, зээлийн хүү, торгуулийн төлбөр нийт 15.0 сая ам.доллар буюу 43.0 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг хийгээгүй;
- Засгийн газрын 2013 оны 80, 2014 оны 261 дүгээр тогтоолыг үндэслэн Тавантолгойн цахилгаан станцын төслийг хэрэгжүүлэх Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-аас олгосон 45.6 тэрбум төгрөгийн зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөр хийгдээгүй;
- Эрдэнэс Монгол ХХК нь 2020 болон түүнээс өмнөх онуудад ТББ, хэвлэл мэдээллийн байгууллагад олгосон гэрээт ажлын төлбөр 0.1 тэрбум төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, авлага барагдуулаагүй;
- Эрдэнэс Тавантолгой ХК нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тиан Юу Групп /Tian YU Group/ компаниас авах 2015 онд үүссэн нүүрсний борлуулалтын 1.2 тэрбум төгрөгийн авлага барагдуулалт удааширч, тайлант хугацаанд 100 хувь найдваргүй авлага болгон бүртгэсэн.

Нийгмийн даатгалын сангийн авлага

Нийгмийн даатгалын сангийн авлагын эхний үлдэгдэл 1,001.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,035.3 тэрбум болж, 33.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №14. Авлагын дансны үлдэгдэл, байгууллагын төрлөөр */сая.төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Төлбөртэй үйлчилгээний авлага	197,168.7	297,410.4	100,241.7	28.7
Татаас, санхүүжилтийн авлага	691,612.9	651,458.4	-40,154.5	62.9
Байгууллагаас авах авлага	112,575.7	86,389.9	-26,185.5	8.3
Хувь хүмүүсээс авах авлага	86.0	65.8	-20.2	0.1
Дүн	**1,001,443.3**	**1,035,324.5**	**33,881.2**	**100.0**

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төлбөртэй үйлчилгээний авлага 100.2 тэрбум төгрөгөөр өссөнд дэлхий нийтийг хамарсан /Ковид-19/ цар тахлын улмаас хөл хорио тогтоож, аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаа доголдсон, мөн эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний хүрээнд нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй аж ахуйн нэгж байгууллагыг алданги, торгуулиас чөлөөлсөн зэрэг нь нөлөөлсөн байна.

Капитал банкнаас авах 103.4 тэрбум төгрөгийн авлагаас 22.1 тэрбум төгрөгийг үл хөдлөх хөрөнгөөр, 7.2 тэрбум төгрөгийг мөнгөн хэлбэрээр барагдуулсан бөгөөд 74.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль, дагалдах журмаар 2021 онд 38.8 мянган ажил олгогч байгууллагын 410.7 мянган албан журмын даатгуулагчийн 144.7 тэрбум төгрөг, 169.2 мянган сайн дурын даатгуулагчийн 15.3 тэрбум төгрөг, нийт 160.0 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл чөлөөлснийг авлагаар бүртгэсэн байна

Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 167.5 тэрбум, эцсийн үлдэгдэл 117.0 тэрбум болж, 50.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №15. Авлагын үлдэгдэл */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагсадтай холбогдсон авлага	0.9	-	-0.9	-
Татаас, санхүүжилтийн авлага	26,495.3	23,945.1	-2,550.2	20.5
Төлбөртэй үйлчилгээний авлага	137.8	-	-137.8	-
Бусад авлага	140,893.9	93,029.7	-47,864.2	79.5
Дүн	**167,527.9**	**116,974.8**	**-50,553.1**	**100.0**

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дараах авлагуудыг барагдуулсан нь дансны үлдэгдэл буурахад нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Капитал банкнаас авах авлагыг мөнгөн хэлбэрээр 7.2 тэрбум, үл хөдлөх хөрөнгөөр 36.5 тэрбум төгрөг;
- Нийгмийн даатгалын ерөнхий газраас авах шимтгэлийн авлага 2.2 тэрбум төгрөг;
- Арилжааны банканд байршуулсан сангийн чөлөөт үлдэгдлийн хүүгийн авлага 3.9 тэрбум төгрөг.

4.4 УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 2,295.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 3,607.7 тэрбум болж, 1,312.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №16. Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,384,037.0	2,713,042.4	1,329,005.4	75.2
Төсөвт байгууллага	666,165.8	608,597.2	-57,568.6	16.9
Төсөл/сан	245,396.8	286,059.8	40,663.0	7.9
Дүн	**2,295,599.6**	**3,607,699.4**	**1,312,099.8**	**100.0**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны өсөлтөд Эрдэнэс Тавантолгой ХК Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын санхүүжилтэд 348.8 тэрбум, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын санхүүжилтэд 273.4 тэрбум, Тавантолгой дулааны станцын төсөлд 5.7 тэрбум, Тавантолгой нүүрс ачилт логистикийн төвийн санхүүжилтэд 81.0 тэрбум, Тавантолгой төмөр зам ХХК Тавантолгой-Гашуунсухайт төмөр замын ажлын урьдчилгаанд 819.7 тэрбум төгрөгийн нүүрсийг гүйцэтгэгчид нийлүүлсэн нь голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

- Тайлант оны эцэст төлбөрийг урьдчилан шилжүүлсэн /БШУЯ 0.04 тэрбум, ОНТЕЗ 0.1 тэрбум төгрөг/;
- Тайлант оны эцэст 6.3 тэрбум төгрөгийн урьдчилж гарсан зардлыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй /ЗТХЯ 0.2 тэрбум, ОНТЕЗ 6.1 тэрбум төгрөг/;
- Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 12.2 тэрбум төгрөгийн ТЭЗҮ, судалгааны ажлуудын гэрээ дүгнэсэн акт дутуу, бусад эргэлтийн хөрөнгөд бүртгээгүй.

4.5 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 2,735.2 тэрбум, эцсийн үлдэгдэл 2,507.0 тэрбум болж, 228.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №17. Бараа материал данс байгууллагын төрлөөр */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,748,723.6	1,261,087.2	-487,636.4	50.3
Төсөвт байгууллага	940,945.4	1,177,346.5	236,401.1	47.0
Төсөл/сан	45,538.8	68,581.9	23,043.1	2.7
Дүн	**2,735,207.8**	**2,507,015.6**	**-228,192.2**	**100.0**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн бууралтад Монголын төмөр зам ТӨХК-ийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төслийн 1,044.3 тэрбум төгрөгийг дуусаагүй үйлдвэрлэлийн данснаас хасаж, дуусаагүй барилга дансанд буюу эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмыг зөрчиж 60.7 тэрбум төгрөгийн бараа, материалын худалдан авалт хийсэн /ХХААХҮЯ 29.3 тэрбум, УУХҮЯ 23.3 тэрбум, ЭХЯ 5.3 тэрбум, ЭМЯ 2.1 тэрбум, ХНХЯ 0.2 тэрбум, ШЕЗ 0.1 тэрбум, МУЕС 0.1 тэрбум, МУШС 0.1 тэрбум, МУЕП 0.1 тэрбум, ЗТХЯ 0.1 тэрбум/;
- Бараа материалын дансны ангилал буруу бүртгэсэн, зардалд шууд тусгасан 15.2 тэрбум төгрөг; /ЭМЯ 5.6 тэрбум, ЭХЯ 4.6 тэрбум, ХНХЯ 1.4 тэрбум, МУШС 1.2 тэрбум, БШУЯ 0.7 тэрбум, УУХҮЯ 0.7 тэрбум, БХБЯ 0.5 тэрбум, ШЕЗ 0.2 тэрбум, ЗТХЯ 0.1 тэрбум, ХЗДХЯ 0.1 тэрбум, ХХААХҮЯ 0.1 тэрбум/;
- Бараа материалын тооллого хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй 26.3 тэрбум төгрөг; /ЭМЯ 26.2 тэрбум, ЭХЯ 0.1 тэрбум/;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу зэрэг бүртгэл тайлагналтай холбоотой 12.1 тэрбум төгрөг; /УУХҮЯ 5.5 тэрбум, ЭМЯ 2.8 тэрбум, ХНХЯ 1.0 тэрбум, МУШС 0.6 тэрбум, ХХААХҮЯ 0.6 тэрбум, ЗТХЯ 0.4 тэрбум, ХЗДХЯ 0.4 тэрбум, ЭХЯ 0.4 тэрбум, БШУЯ 0.3 тэрбум, МУЕП 0.1 тэрбум/;
- Бараа материалын үлдэгдэлд хэрэглээнээс илүү бэлтгэсэн, хугацаа хэтэрсэн, ашиглалтгүй, он дамжин хөдөлгөөн хийгдээгүй, эргэлт удааширсан 5.9 тэрбум төгрөгийн ашиглах эсэх нь тодорхойгүй бараа материалын үлдэгдэлтэй;
- Үр ашиггүй зарцуулсан, нөөц үүсгэсэн 3.9 тэрбум төгрөг; /ЭМЯ 1.7 тэрбум, УУХҮЯ 2.2 тэрбум/.

4.6 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,254.3 тэрбум, эцсийн үлдэгдэл 6,145.7 тэрбум болж, 108.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №18. Бусад эргэлтийн хөрөнгө данс байгууллагын төрлөөр */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,059,271.7	946,957.6	-112,314.1	15.4
Төсөвт байгууллага	4,183,021.1	3,789,673.8	-393,347.3	61.7
Төрийн сан	22,295.4	23,506.6	1,211.2	0.4
Төсөл/сан	989,683.4	1,385,573.9	395,890.5	22.5
Дүн	**6,254,271.6**	**6,145,711.9**	**-108,559.7**	**100.0**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгө дансны бууралтад ЗТХЯ гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн авто замын төслийн барилгын ажлуудыг ТӨБЗГ-ын тогтоолыг үндэслэн үндсэн хөрөнгийн дансанд, УБЕГ-ын өмнөх онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд тус тус шилжүүлэн бүртгэсэн нь голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

- ЭМЯ-ны бусад эргэлтийн хөрөнгийн дансанд 2019-2021 онд улсын комиссын дүгнэлт гарч, ашиглалтад орсон 153.8 тэрбум төгрөгийн 64 барилга бүртгэлтэй;
- ЭХЯ 2014 онд улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн "Хөтөл хорооны 6кв цахилгаан дамжуулах агаарын шугам, 6/0.4 кв дэд станц, 0.4 кв цахилгаан дамжуулах агаарын шугам татах" 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг шийдвэрлээгүй;
- БХБЯ Буянт-Ухаа 2 хороллын борлуулсан 18 байрны 1.3 тэрбум төгрөгийн төлбөрийг үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гараагүй үндэслэлээр бүртгэлээс хасаагүй;
- ЗГХЭГ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дуусан барилга байгууламж, тоног төхөөрөмжийг гүйцэтгэл ирүүлээгүй үндэслэлээр ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байна.

4.7 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 10,040.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 10,580.4 тэрбум төгрөг болж, 540.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №19. Урт хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагын төрлөөр */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Урт хугацаат хадгаламж	490,969.2	449,091.7	-41,877.5	4.2
Үнэт цаас	2,329,124.3	2,511,661.5	182,537.2	23.7
Урт хугацаат зээл	7,220,309.7	7,619,640.8	399,331.1	72.1
Дүн	**10,040,403.2**	**10,580,394.0**	**539,990.8**	**100.0**
Үүнээс, байгууллагын төрлөөр харуулбал:				
Төсөвт байгууллага	15,897.6	56,551.7	40,654.1	0.5
Төрийн сан	2,297,369.0	2,100,436.8	-196,932.2	19.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	7,727,136.6	8,423,405.5	696,268.9	79.6
Дүн	**10,040,403.2**	**10,580,394.0**	**539,990.8**	**100.0**

Эх сурвалж:Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалтын 0.5 хувийг төсвийн байгууллага, 19.9 хувийг Төрийн сан, 79.6 хувийг төрийн өмчит, болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хадгаламж, үнэт цаас, урт хугацаат зээлээрх хөрөнгө оруулалт эзэлж байна.

Урт хугацаат хадгаламжийн үлдэгдэлд Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн гадаад банканд байршуулсан 393.6 тэрбум, Үндэсний давхар даатгал ХХК-ийн арилжааны банканд байршуулсан 55.4 тэрбум төгрөг байна.

Урт хугацаат үнэт цаасны өсөлтөд Монголын төмөр зам ТӨХК Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам барих төслийн 230.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг Тавантолгой төмөр зам ХХК-д балансаас балансад шилжүүлж, урт хугацаат хөрөнгө оруулалтаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, Монгол Улсын Хөгжлийн банк ХХК Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 142.4 тэрбум төгрөгийн үнэт цаасанд хөрөнгө оруулсан, Төрийн банк ХХК Засгийн газрын 2019 оны 255 болон Төрийн банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 01 дүгээр тогтоолоор хоёрдогч өглөгийн үлдэгдэл 64.5 тэрбум төгрөгийг энгийн хувьцаанд хөрвүүлж Сангийн яаманд эзэмшүүлсэн зэргээс шалтгаалжээ.

Төрийн сангийн урт хугацаат үнэт цаасны бууралтад Монголбанкны эзэмшиж буй Засгийн газрын "Сайн хувьцаа" үнэт цаасны төлбөрийг Сангийн яамны эзэмшиж буй давуу эрхтэй 216.5 тэрбум төгрөгийн ипотекийн зээлээр баталгаажсан бондоор барагдуулснаас шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- Засгийн газар, Монголбанк хамтран эзэмшиж буй "Орон сууцны ипотекийн зээлийн тогтвортой тогтолцоо бүрдүүлэх хөтөлбөр"-ийн ипотекийн зээлээр баталгаажсан 216.5 тэрбум төгрөгийн давуу эрхтэй бондыг Монголбанканд шилжүүлсэн нь Улсын Их Хурлын 2021 оны "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай" 91 дүгээр тогтоолын 4-т "орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлж эхлэх бэлтгэл ажлын хүрээнд Монголбанк хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт 2023 онд багтаан бүрэн шилжүүлэх, энэ хугацаанд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

4.8 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл цэвэр дүнгээр 45,820.9 тэрбум, эцсийн үлдэгдэл 49,675.0 тэрбум болж, 3,854.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №20. Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Газар	277,258.5	282,698.3	5,439.8	0.6
Биет хөрөнгө	22,889,985.2	25,792,880.0	2,902,894.8	51.9
Биет бус хөрөнгө	17,959,651.0	18,024,096.3	64,445.3	36.3
Бусад хөрөнгө	4,694,001.2	5,575,299.6	881,298.4	11.2
Дүн	**45,820,895.9**	**49,674,974.2**	**3,854,078.3**	**100.0**
Үүнээс, байгууллагын төрлөөр				
ТӨҮГ болон ОНӨҮГ	30,480,942.8	33,130,544.9	2,649,602.1	66.7
Төсөвт байгууллага	14,867,570.8	16,161,732.6	1,294,161.8	32.5
Төсөл/сан	472,382.3	382,696.7	-89,685.6	0.8
Дүн	**45,820,895.9**	**49,674,974.2**	**3,854,078.3**	**100.0**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийн 3,854.1 тэрбум төгрөгийн өсөлтөд ЗТХЯ 1,241.9 тэрбум, УУХҮЯ 1,212.6 тэрбум, БШУЯ 226.3 тэрбум, Нийслэл 156.6 тэрбум, ЭМЯ-ны үндсэн хөрөнгө 146.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Тухайлбал:

- ЗТХЯ дуусаагүй барилга дансанд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416 км төмөр замын барилгын ажлын зардал 1,088.4 тэрбум төгрөгийг дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд шилжүүлэн бүртгэсэн;
- Тавантолгой төмөр зам ХХК тайлант онд Гашуунсухайт төслийн хүрээнд ерөнхий гүйцэтгэгчээс хүлээн авсан ачааны 100 ширхэг вагоныг хөрөнгөөр бүртгэсэн;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2021 онд “Өөрөө нунтаглах хэсгийн жилд 6 сая/тонн хүдэр боловсруулах хүчин чадал бүхий 4 дүгээр шугам”-ыг барих төслийн 158.5 тэрбум, “Жилд 12 сая/тонн хүдэр боловсруулах хам баяжуулалтын секц барих” төслийн 24.5 тэрбум, “Цэвэр ус дамжуулах 3-р шугам угсрах” төслийн 87.2 тэрбум төгрөг, “Баяжуулах үйлдвэрийн өөрөө нунтаглах хэсгийн 2-р шугамын тээрмүүдийг солих ажил”-ын 12.0 тэрбум, “Уурхайчин 2, 3-р хороолол хүртэл дэд бүтэц барих” ажлын 37.7 тэрбум, “Уурхайчин 3 төслийн дэд бүтцийг барих” төслийн 21.3 тэрбум төгрөгийн ажлын гүйцэтгэлийг дуусаагүй барилгын дансанд бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 62.8 тэрбум төгрөгийн хөрөнгийг цаашид ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ болон ОНТӨГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй /ЭХЯ 35.1 тэрбум, БШУЯ 12.6 тэрбум, ШС 5.6 тэрбум, ЭМЯ 2.7 тэрбум, ЗТХЯ 2.6 тэрбум, ОНТЕЗ 1.9 тэрбум, ХЗДХЯ 0.7 тэрбум, Соёлын яам 0.5 тэрбум, Бусад ТЕЗ 1.1 тэрбум төгрөг/;
- Улсын төсвийн хөрөнгө болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болсон 39.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа байгууллагын нэр дээр шилжүүлээгүй /ОНТЕЗ 17.9 тэрбум, БОАЖЯ 17.7 тэрбум, ЗТХЯ 2.9 тэрбум, БХБЯ 0.7 тэрбум, ЗГХЭГ/;
- Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгийг данс бүртгэлийн дүнгээс зөрүүтэй тоолж, баталгаажуулсан 22.1 тэрбум төгрөг /ЭМЯ 15.7 тэрбум, ОНТЕЗ 6.3 тэрбум, бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/;
- Хөрөнгийг данс бүртгэлд тусгахдаа ангилал буруу, зөрүүтэй, бөөн дүнгээр бүртгэсэн, хөрөнгө биетээр оршин байхгүй, данс бүртгэлд тусгаагүй 13.0 тэрбум төгрөг /ОНТЕЗ 9.8 тэрбум, ЭХЯ 1.4 тэрбум, ХНХЯ 0.4 тэрбум, ХХААХҮЯ 0.3 тэрбум, ЗТХЯ 0.2 тэрбум, ХЗДХЯ 0.1 тэрбум, ШЕЗ 0.1 тэрбум, Бусад ТЕЗ 0.7 тэрбум төгрөг/;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй 1.4 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн /ОНТЕЗ 1.2 тэрбум, ЗТХЯ 0.1 тэрбум, Бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/;
- Өмнөх онд аудитаар өгсөн 1.3 тэрбум төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй /ОНТЕЗ 1.3 тэрбум төгрөг/;

- Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүй 0.4 тэрбум, урсгал төсвөөс 0.9 тэрбум төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, акталж данс бүртгэлээс хассан, дахин үнэлж данс бүртгэлд тусгасан /ОНТЕЗ 0.3 тэрбум, бусад ТЕЗ 1.0 тэрбум төгрөг/;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь бүрэн ашиглалтад ороогүй 80.0 хувийн гүйцэтгэлтэй 1.4 тэрбум төгрөгийн 19 амины орон сууцыг барилга байгууламжийн дансанд бүртгэсэн;
- ШШГЕГ-ын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-нэгдсэн эмнэлгийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 5.2 га газрыг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй;
- Ховд аймаг дахь "Хөгжил" Политехник коллеж нь ашиглалтад орсон 960 хүүхдийн шинэ байрыг санхүүжилтийн гүйцэтгэл дутуу, дээд шатны байгууллагаас үндсэн хөрөнгөд бүртгэхгүй гэсэн чиглэлийн дагуу үндсэн хөрөнгийг 4.5 тэрбум төгрөгөөр бууруулж бүртгэсэн;
- Төв аймгийн Баянчандмань суман дахь Политехник коллеж хандиваар ирсэн 2.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг худалдан авсан хөрөнгөөр бүртгэсэн;
- ТӨБЗГ нь БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдсан 5235 м.кв талбайтай, 6 давхар, 27 өрөө бүхий барилгыг тухайн байгууллагын санхүүгийн тайланд 2019 онд бүртгэж, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим ТББ-д үнэ төлбөргүй, 2021 оноос 3 жилийн хугацаанд зөвхөн ашиглалтын зардлаа төлөх нөхцөлөөр гэрээ байгуулан ашиглуулсан;
- Монголын төмөр зам ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд улсын бүртгэлийн болон техникийн гэрчилгээгүй нийт 66.8 тэрбум төгрөгийн 15 хөрөнгө бүртгэлтэй;
- ИНЕГ-ын 59,528 м.кв бүхий 3 газар 2018 онд эзэмшлийн асуудал шийдэгдээгүйгээс дахин үнэлгээнд хамрагдаагүй;
- ТОСК ТӨХК зарим сумдад 40000 айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд барьсан, данс бүртгэлтэй 4 болон 8 айлын 108 чанарын шаардлага хангаагүй орон сууцны үнэ цэнийн бууралтыг бүртгэх нөхцөл үүссэн боловч холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй.

4.9 ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 42,659.8 тэрбум, эцсийн үлдэгдэл 45,153.2 тэрбум болж, 2,493.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №21. Нийт өр, төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	5,203,111.5	6,894,084.2	1,690,972.7	15.3
Богино хугацаат үнэт цаас	228,045.1	15,575.3	-212,469.8	0.1
Богино хугацаат зээлийн өглөг	1,605,983.3	1,587,480.1	-18,503.2	3.5
Өглөг	2,280,976.6	2,941,513.3	660,536.7	6.5
Урьдчилж орсон орлого	1,088,106.5	2,349,515.5	1,261,409.0	5.2
Урт хугацаат өр төлбөр дүн	37,456,704.0	38,259,128.1	802,424.1	84.7
Урт хугацаат үнэт цаас	14,634,581.3	15,094,752.3	460,171.0	33.4
Урт хугацаат зээл	22,822,122.7	23,164,375.8	342,253.1	51.3
Дүн	**42,659,815.5**	**45,153,212.3**	**2,493,396.8**	**100.0**
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төрийн сан	27,372,464.7	27,052,581.1	-319,883.6	60.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	14,510,898.8	16,722,030.2	2,211,131.4	37.0
Төсөвт байгууллага	354,079.5	692,552.6	338,473.1	1.5
Төсөл/сан	422,372.5	686,048.4	263,675.9	1.5
Дүн	**42,659,815.5**	**45,153,212.3**	**2,493,396.8**	**100.0**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт богино хугацаат өр төлбөрийн 1,691.0 тэрбум төгрөгийн өсөлтөд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 797.8 тэрбум, Төрийн сангийн 282.9 тэрбум, төсөвт байгууллагын 331.3 тэрбум, төсөл сангийн 278.9 тэрбум төгрөгөөр богино хугацаат өр төлбөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Сүүлийн 3 жилд гадаад бонд, зээлийн ханшийн зөрүүнээс нийт 1,200.6 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн нь төсөвт ачаалал нэмэгдэж, өрийг өрөөр дахин санхүүжүүлэх нөхцөлийг бий болгож байна.

Үнэт цаас, зээлийн өглөг

Нийт өр төлбөрийн 88.3 хувь буюу 39,862.2 тэрбум төгрөгийг үнэт цаас, зээлийн өглөг эзэлж байна.

Хүснэгт №22. Үнэт цаас, зээлийн өглөг */сая төгрөг/*

Үнэт цаасны зориулалт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төв төрийн сангийн өглөг	**26,850,113.1**	**26,247,304.4**	**-602,808.7**	**65.9**
Дотоод бонд	1,151,741.1	672,456.0	-479,285.1	1.7
Гадаад үнэт цаас, бонд, зээлийн өглөг	25,698,372.0	25,574,848.4	-123,523.6	64.2
Гадаад бондын өглөг	8,355,180.9	8,137,018.4	-218,162.5	20.4
Үнэт цаас	1,129,380.5	1,203,458.1	74,077.6	3.1
Гадаад зээл /хөнгөлөлттэй/	16,213,810.6	16,234,371.9	20,561.3	40.7
ТБОНӨҮГ-ын өглөг	**12,201,184.9**	**13,322,600.5**	**1,121,415.6**	**33.4**
Дотоод бонд	1,007,579.0	1,967,384.7	959,805.7	4.9
Зээлийн өглөг	6,870,311.8	7,290,982.6	420,670.8	18.3
Гадаад үнэт цаас, бонд, зээлийн өглөг	4,323,294.1	4,064,233.1	-259,061.0	10.2
Гадаад бондын өглөг	3,147,502.4	2,976,200.7	-171,301.7	7.5
Үнэт цаас	71,242.5	153,809.7	82,567.2	0.4
Гадаад зээл	1,104,549.2	934,222.7	-170,326.5	2.3
Бусад байгууллагын зээлийн өглөг	**239,434.5**	**292,278.6**	**52,844.1**	**0.7**
Гадаад зээл	196,156.5	181,740.0	-14,416.5	0.4
Зээлийн өглөг	43,278.0	110,538.6	67,260.6	0.3
Дүн	**39,290,732.5**	**39,862,183.5**	**571,451.0**	**100.0**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд Төв төрийн сангийн үнэт цаас, зээлийн өглөг 602.8 тэрбум төгрөгөөр буурч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн үнэт цаас, зээлийн өглөг 1,121.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт үнэт цаас, зээлийн өглөгийн 65.9 хувь буюу 26,247.3 тэрбум төгрөгийг Төв төрийн сангийн өр төлбөр эзэлж байна.

Төв төрийн сангийн үнэт цаас, зээл

Хүснэгт №23. Төв төрийн сангийн бонд, гадаад зээлийн өглөг */сая төгрөг/*

Үзүүлэлт	Дотоод бонд	Гадаад бонд	Гадаад зээл	Дүн
Нэмэгдсэн дүн	**-**	**2,847,539.9**	**753,411.8**	**3,600,951.7**
Бонд	-	2,849,220.0	-	2,849,220.0
Зээлийн ашиглалт	-	-	1,391,446.0	1,391,446.0
Ханшийн алдагдал	-	-1,680.1	-638,034.2	-639,714.3
Хасагдсан дүн	**479,285.1**	**3,025,678.6**	**732,850.5**	**4,237,814.2**
Үндсэн төлбөр	479,285.1	3,025,678.6	732,850.5	4,237,814.2
Хүүгийн төлбөр	**118,648.7**	**468,108.4**	**212,874.0**	**799,631.1**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төв төрийн сангийн үнэт цаас, зээл 3,601.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 4,237.8 тэрбум төгрөгөөр хасагдсан байна.

Тайлант онд “Мазаалай” бондын 377.8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс төлж барагдуулсан ба олон улсын зах зээлд 2,849.2 тэрбум төгрөгийн “Сенчири-2027”, “Сенчири-2031” бондыг арилжаалж, 2022 онд “Чингис” бондын 1,887.4 тэрбум, 2023 онд “Гэрэгэ” бондын 760.5 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх төлбөрийг дахин санхүүжүүлэх өрийн зохицуулалтын арга хэмжээ авсан байна.

Төсөл, хөтөлбөрийн зээлийн ашиглалт 1,391.4 тэрбум, валютын ханшийн зөрүүгээр 638.0 тэрбум төгрөгийн олз үүсэж, гадаад зээл нийт 753.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, үндсэн төлбөр 732.9 тэрбум төгрөгийг төлсөн байна.

Дотоод бондын үндсэн төлбөр 479.3 тэрбум төгрөгөөр буурсан нь Сангийн яамны эзэмшиж буй ипотекийн зээлээр баталгаажсан бонд болон санхүүжилтийн авлагын нэрлэсэн үнэ цэнээр үнэлсэн 263.3 тэрбум төгрөгөөр “Сайн хувьцаа” бондын өрийг хэсэгчлэн барагдуулж, бондын үндсэн төлбөрт 216.0 тэрбум төгрөгийг төлсөнтэй холбоотой байна.

Хүүгийн төлбөрт дотоод бондын 118.6 тэрбум, гадаад бондын 468.1 тэрбум, гадаад зээлийн 212.9 тэрбум, нийт 799.6 тэрбум төгрөгийг улсын төсвөөс төлжээ.

Аудитын илрүүлэлт:

- Урт хугацаат дотоод бондын хөнгөлөлт 15.5 тэрбум төгрөгийг богино хугацаат өр төлбөрийн ангилалд, гаалийн түр горимын өглөг 18.4 тэрбум төгрөгийг бусад өглөгийн дансанд бүртгэсэн;
- Эрдэнэс Монгол ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2017 оны 154 дүгээр тогтоолд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааг худалдаж авсан аж ахуйн нэгж хүсэлт гаргасан тохиолдолд тэдгээрийн хувьцааг буцаан худалдан авах арга хэмжээг 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөр тасалбар болгон хэрэгжүүлэхээр заасан байна. Үүний дагуу хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийн хувьцааг буцаан худалдан авах арга хэмжээг хэрэгжүүлж дуусан боловч Төв төрийн сангийн санхүүгийн тайланд 6.6 тэрбум төгрөгийн өглөг бүртгэлтэй байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөрийн эхний үлдэгдэл 14,510.9 тэрбум, эцсийн үлдэгдэл 16,722.0 тэрбум төгрөг болж, 2,211.1 тэрбум төгрөгөөр өссөн.

Хүснэгт №24. Төрийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	*4,113,838.8*	*4,911,645.1*	*797,806.3*	*29.4*
Богино хугацаат үнэт цаас	212,469.8	0.0	-212,469.8	0.0
Богино хугацаат зээлийн өглөг	1,591,655.0	1,512,215.4	-79,439.6	9.0
Өглөг	1,658,746.6	1,848,627.5	189,880.9	11.1
Урьдчилж орсон орлого	650,967.4	1,550,802.2	899,834.8	9.3
Урт хугацаат өр төлбөр дүн	*10,397,060.0*	*11,810,385.1*	*1,413,325.1*	*70.6*
Урт хугацаат үнэт цаас	4,013,854.0	5,097,395.1	1,083,541.1	30.5
Урт хугацаат зээл	6,383,206.0	6,712,990.0	329,784.0	40.1
Дүн	**14,510,898.8**	**16,722,030.2**	**2,211,131.4**	**100.0**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 6,713.0 тэрбум төгрөг нь урт хугацаат зээл, 5,097.4 тэрбум төгрөг нь үнэт цаас, 11,810.4 тэрбум төгрөг нь бусад өглөг байна.

Урт хугацаат үнэт цаас 1,083.5 тэрбум төгрөгөөр өсөхөд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 692.5 тэрбум, Эрдэнэс Монгол ХХК-ийн 44.3 тэрбум, Төрийн банк ХХК-ийн 82.5 тэрбум, Монголын төмөр зам ТӨХК-ийн 270.4 тэрбум төгрөгийн урт хугацаат үнэт цаас нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Эрдэнэс Тавантолгой ХК Засгийн газрын “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын төлөвлөгөө”-ний хүрээнд “ЭТТ БОНД”-ын 1, 2 дугаар транчийн арилжааг амжилттай зохион байгуулж, 692.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлж, Тавантолгой дулааны цахилгаан станц, Нүүрс баяжуулах үйлдвэр, Усан хангамж, Төмөр замын төслүүдийг санхүүжүүлэхэд зарцуулсан;
- Эрдэнэс Монгол ХХК бондын авлагын хямдруулалтын тохируулгаар 44.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн;
- Монголын төмөр зам ТӨХК-ийн бусад урт хугацаат өр төлбөр 270.4 тэрбум төгрөгөөр өссөн нь Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төслийг тайлант онд санхүүжүүлэх дүнгээр нэмэгдсэн;
- Төрийн банк ХХК заавал байх нөөцийн хэмжээгээр Монголбанкнаас 82.5 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан.

Аудитын илрүүлэлт:

- Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой 180 хуулийн этгээд 1,649.4 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй боловч 76.1 тэрбум төгрөгийн татвар, НДШ-ийн өглөгийг барагдуулаагүй;
- Эрдэнэс Монгол ХХК-ийн өр төлбөртэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. ТӨБЗГ-ын 2021 оны 228 дугаар тогтоолоор 2020 оны цэвэр ашгаас тогтоосон 0.8 тэрбум төгрөгийн ногдол ашгийг өр төлбөрөөр бүртгэзгүй;
2. Асгатын мөнгөний ордын хүдрийн дээжид лабораторийн туршилт судалгаа хийх ажлын гэрээний дүнгээр хайгуул үнэлгээний хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрснөөс шалтгаалан хэрэгжээгүй гэрээний үлдэгдлээр хайгуул үнэлгээний хөрөнгө, өр төлбөрийг 0.5 тэрбум төгрөгөөр илүү илэрхийлсэн;
3. Эрдэнэс Монгол ХХК түүний охин компаниудын хооронд үүссэн нийт 936.0 тэрбум төгрөгийн бондын хөрөнгө, урт хугацаат авлага, өр төлбөрийн үлдэгдлийг санхүүгийн нэгтгэсэн тайланд давхар илэрхийлсэн;
4. Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-д 2022 онд төлөгдөх 17.5 тэрбум төгрөгийг урт хугацаат зээлээр бүртгэсэн, хугацаандаа төлөөгүй зээлийн үлдэгдэл 18.9 тэрбум, зээлийн хүү 8.8 тэрбум төгрөг байгаа нь тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварт сөргөөр нөлөөлсөн.

Төсөвт байгууллагын өр төлбөр

Төсөвт байгууллагын өр төлбөрийн эхний үлдэгдэл 354.1 тэрбум, эцсийн үлдэгдэл 692.6 тэрбум болж, 338.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №25. Төсвийн байгууллагын нийт өр, төлбөр */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	*325,201.3*	*656,548.2*	*331,346.9*	*94.8*
Богино хугацаат зээлийн өглөг	1,858.9	74,597.2	72,738.3	10.8
Өглөг	247,998.9	482,274.6	234,275.7	69.6
Урьдчилж орсон орлого	75,343.5	99,676.4	24,332.9	14.4
Урт хугацаат өр төлбөр дүн	*28,878.2*	*36,004.4*	*7,126.2*	*5.2*
Үүнээс, ТЕЗ-ийн төрлөөр				
УТЕЗ	265,472.0	510,157.9	244,685.9	73.7
ОНТЕЗ	88,607.5	182,394.7	93,787.2	26.3
Дүн	**354,079.5**	**692,552.6**	**338,473.1**	**100.0**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 73.7 хувийг улсын төсвийн, 26.3 хувийг орон нутгийн төсвийн байгууллагуудын үлдэгдэл эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 656.5 тэрбум /ЭМЯ 175.7 тэрбум, Нийслэл 92.4 тэрбум, ХЗДХЯ 80.2 тэрбум, ЗТХЯ 61.6 тэрбум, БХБЯ 44.6 тэрбум, ХНХЯ 36.2 тэрбум, БОАЖЯ 22.8 тэрбум, Өмнөговь 17.0 тэрбум, Орхон 10.9 тэрбум, бусад ТЕЗ 115.1 тэрбум төгрөг/, урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 36.0 тэрбум төгрөг /ХХААХҮЯ 1.4 тэрбум, Нийслэл 34.1 тэрбум, бусад ТЕЗ 0.5 тэрбум төгрөг/ байна.

Аудитын илрүүлэлт:

- Тайлант онд 56.8 тэрбум төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй /БШУЯ 1.0 тэрбум, БОАЖЯ 0.3 тэрбум, ЗГХЭГ 0.2 тэрбум, УУХҮЯ 0.8 тэрбум, ХХААХҮЯ 31.4 тэрбум, ЭМЯ 0.4 тэрбум, ЭХЯ 0.4 тэрбум, ШС 0.2 тэрбум, Хөвсгөл 17.0 тэрбум, Нийслэл 4.7 тэрбум, Архангай 0.1 тэрбум, Баянхонгор 0.2 тэрбум, Төв 0.1 тэрбум төгрөг/;
- Нийт 331.4 тэрбум төгрөгийн өглөгийг барагдуулаагүй /БОАЖЯ 0.5 тэрбум, БШУЯ 0.1 тэрбум, ГХЯ 0.6 тэрбум, ЗТХЯ 1.2 тэрбум, ХЗДХЯ 0.2 тэрбум, ЭМЯ 0.7 тэрбум, ЭХЯ 43.0 тэрбум, ЭМДС 264.5 тэрбум, Нийслэл 0.6 тэрбум, Архангай 1.8 тэрбум, Баянхонгор 0.5 тэрбум, Дорноговь 17.3 тэрбум, Ховд 0.4 тэрбум төгрөг/;
- БХБЯ хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд бүртгэсэн олон жилийн насжилттай, гүйцэтгэгч гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн 19 аж ахуйн нэгж, байгууллагын 0.1 тэрбум төгрөгийн барьцаа хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- УУХҮЯ 8.5 тэрбум төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд бүртгэзгүй;
- ХЗДХЯ санхүүгийн тайланд 1.3 тэрбум төгрөгийн өр төлбөрийг бүртгэж тайлагнаагүй;
- Дамжуулан зээлдүүлэх гэрээ хийсэн хуулийн этгээдтэй урт хугацаат зээлийн гэрээг байгуулаагүй, татварын байгууллагын тооцооллоос өглөгийг зөрүүтэй илэрхийлсэн, өрийг барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй /Булган 12.8 тэрбум, Говь-Алтай 0.1 тэрбум, Сүхбаатар 0.3 тэрбум төгрөг/.

Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөр

Нийгмийн даатгалын сангийн өр төлбөр дансны эхний үлдэгдэл 27.0 тэрбум, эцсийн үлдэгдэл 24.6 тэрбум төгрөг болж, 2.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөр дансны эхний үлдэгдэл 2.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 268.1 тэрбум төгрөг болж 265.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж гүйцэтгэлээр санхүүждэг болсонтой холбоотойгоор тайлант онд 264.5 тэрбум төгрөгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн өглөг үүссэн. Үүнээс /Ковид-19/ цар тахлын эсрэг цогц тусламж үйлчилгээний өглөг 174.4 тэрбум төгрөг байна.

4.10 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 35,887.5 тэрбум, эцсийн үлдэгдэл 37,964.9 тэрбум төгрөг болж, 2,077.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №26. Засгийн газрын хувь оролцоо */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	8,407,367.3	8,496,739.0	89,371.7	22.4
Өмч	15,241,006.5	15,663,952.9	422,946.4	41.3
Нэмж төлөгдсөн капитал	7,412.0	4,081.9	-3,330.1	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг	7,823,617.4	9,354,177.7	1,530,560.3	24.6
Хуримтлагдсан үр дүн	-3,473,456.3	-3,381,938.0	91,518.3	-8.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,881,593.5	7,827,957.2	-53,636.3	20.6
Засгийн газрын хувь оролцооны дүн	35,887,540.4	37,964,970.7	2,077,430.3	100.0
Хяналтын бус хувь оролцоо	4,676.2	4,684.1	7.9	
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	**35,892,216.6**	**37,969,654.8**	**2,077,438.2**	**100.0**

Эх сурвалж: Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд төрийн өмчийн 6, орон нутгийн өмчийн 4 хуулийн этгээдийн 4.7 тэрбум төгрөгийн цөөнхийн хувь оролцоог тусдаа толилуулсан байна.

Засгийн газрын оруулсан капитал данс 89.4 тэрбум, өмч 422.9 тэрбум, эздийн өмчийн бусад хэсэг 1,530.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь тайлант онд шинээр нэгтгэгдсэн байгууллагууд болон төсөл хөтөлбөр, улс орон нутгийн хөрөнгө оруулалт, төрийн өмчит хуулийн этгээдийн өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хөрөнгө нэмэгдсэн зэрэг голлон нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Тавантолгой төмөр зам ХХК-д толгой компаниудаас /Монголын Төмөр зам ТӨХК 34 хувь Эрдэнэс Тавантолгой ХК 66 хувь/ оруулсан хөрөнгө оруулалтыг хувьцаанд хөрвүүлэхээр хүлээгдэж байгаа 819.7 тэрбум төгрөгийг бүртгэсэн;
- Зүүнбаян Төмөр зам ХХК-ийн хувьцаа эзэмшигч Эрдэнэс-Тавантолгой ХК-аас төмөр замын суурь бүтэц барих төслийн санхүүжилтэд шилжүүлсэн 270.4 тэрбум, компанийн үйл ажиллагааны санхүүжилтэд олгосон 3.0 тэрбум, нийт 273.4 тэрбум төгрөгөөр өмчийг нэмэгдүүлсэн;
- Оюу толгой ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 4/21, 3 дугаар сарын 12-ны өдрийн 10/21, 3 дугаар сарын 15-ны өдрийн 12/21 дүгээр тушаалуудыг үндэслэн Эрдэнэс Оюу толгой ХХК-д оруулсан урт хугацаат хөрөнгө оруулалтын дүнгээр эзэмшигчийн өмчийг 58.1 тэрбум төгрөгөөр буюу 5,813,541 ширхэг хувьцаагаар нэмэгдүүлсэн.
- Төрийн банк ХХК хоёрдогч өглөгийг хөрвүүлснээр энгийн хувьцааны тоо 44,100 ширхгээр нэмэгдэж, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 44.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн;

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу цахилгаан, уур ус, дулаан, энгийн хог хаягдлын төлбөр 1,036.8 тэрбум төгрөг болж хуримтлагдсан ашгийг бууруулж бүртгэсэн байна.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАГДМАЛ САНАЛ ДҮГНЭЛТ

Хөрөнгийн дахин үнэлгээний бууралтад Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ ТӨБЗГ-ын шийдвэрээр акталж, данснаас хассан 79.4 тэрбум төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 27.6 тэрбум, бусад байгууллагуудын хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлтөөр 26.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

4.11 ОНЦОЛСОН БОЛОН БУСАД АСУУДАЛ

4.11.1 Онцолсон асуудал

Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 /арван/ их наядын цогц төлөвлөгөө"-ний 2.11 "Дотоодын үнэт цаасны зах зээлд өрийн бичиг "ЭТТ БОНД" гаргаж, уул уурхай зам, тээврийн салбарын томоохон бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг эхлүүлэх"-ээр тусгасны дагуу Эрдэнэс Тавантолгой ХК-ийн орлогоор баталгаажсан ЭТТ Бондын I, II шатны арилжааг зохион байгуулжээ.

4.11.2 Бусад асуудал

Засгийн газраас хэрэгжүүлж буй "Цахим Монгол" хөтөлбөрийн хүрээнд халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж, Халамжийн нэгдсэн систем буюу https://ehalamj.mn/ цахим системийг хөгжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн E-Mongolia системтэй холбосон байна. Уг системд 26 төрлийн 112 шифр үйлчилгээг цахимжуулснаар давхардсан тоогоор хоёр сая орчим иргэн цахим үйлчилгээ авах боломжтой болжээ.

4.11.3 Аудитын гол асуудал

Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу айл өрхийн болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрөөс хариуцахаар заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нийгмийн хариуцлагын хүрээнд 2021 оны цэвэр ашгаас нийт 1,036.8 тэрбум төгрөгийн төлбөрөөс 883.5 тэрбум төгрөгийг төлсөн байна.

4.12 ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитад Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, Төв төрийн сангийн санхүүгийн тайлан, улсын болон орон нутгийн 57 төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 6973 төсвийн захирагч, төрийн өмчит болон тэдгээрийн оролцоотой хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгж санхүүгийн тайлан нийт 7032 санхүүгийн тайлан хамрагдахаас 4037 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж /Зөрчилгүй 3413, Хязгаарлалттай 568, Сөрөг 37, Санал дүгнэлт гаргахаас татгалзсан 19/, 2933 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй, татан буугдсан нийт 62 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулаагүй.

Аудитаар нийт 10,471.7 тэрбум төгрөгийн 17513 алдаа, зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэлийн тайлагнал, дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 2,284.6 тэрбум төгрөгийн 5243 алдааг аудитын явцад залруулж, 69.6 тэрбум төгрөгийн зөрчилд 1731 төлбөрийн акт тогтоож, 4,142.3 тэрбум төгрөгийн зөрчилд 3999 албан шаардлага, 7.8 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 152 санал хүргүүлж, 3,966.4 тэрбум төгрөгийн 6375 зөрчилд зөвлөмж өгч, 1.0 тэрбум төгрөгийн 13 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүллээ.

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

Улсын төсвийн 33 ерөнхийлөн захирагч, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүгийн тайланд аудит хийж Зөрчилгүй 25, Хязгаарлалттай 10 дүгнэлт өглөө.

Аудитад улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний 1583 төсвийн захирагч, төрийн өмчит болон тэдгээрийн оролцоотой хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгж санхүүгийн тайлан хамрагдахаас 1200 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж /Зөрчилгүй 1037, Хязгаарлалттай 149, Сөрөг 10, Санал дүгнэлт гаргахаас татгалзсан 4/, 371 санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, 12 байгууллагыг тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй, татан буугдсан зэрэг шалтгаанаар аудитад хамруулаагүй.

Аудитаар нийт 6,199.8 тэрбум төгрөгийн 5183 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 1,907.0 тэрбум төгрөгийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 1602 алдааг залруулж, залруулагдаагүй алдаа болон хууль, эрх зүйн актын холбогдох заалттай нийцээгүй 61.0 тэрбум төгрөгийн зөрчилд 422 төлбөрийн акт тогтоож, 2,926.2 тэрбум төгрөгийн зөрчилд 1160 албан шаардлага, 5.9 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 33 санал хүргүүлж, 1,298.9 тэрбум төгрөгийн зөрчилд 1959 зөвлөмж өгч, 0.8 тэрбум төгрөгийн 7 асуудлыг хуулийн байгууллагад шилжүүллээ.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

Орон нутгийн 22 төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Зөрчилгүй 18, Хязгаарлалттай 4 /Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Увс/ дүгнэлт өгсөн байна.

Аудитад орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний 5303 төсвийн захирагч, орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөл, хөтөлбөрийн нэгжийн тайлан, зардлын дансыг хамруулахаас 2836 байгууллагад дүгнэлт гаргаж /Зөрчилгүй 2376, Хязгаарлалттай 418, Сөрөг 27, Санал дүгнэлт гаргахаас татгалзсан 15/, 2417 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан, 50 байгууллагыг тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй, татан буугдсан зэрэг шалтгаанаар аудитад хамруулаагүй.

Аудитаар нийт 579.7 тэрбум төгрөгийн 12319 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 319.1 тэрбум төгрөгийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 3638 алдааг залруулж, хууль, тогтоомжийн холбогдох заалтыг зөрчсөн 8.6 тэрбум төгрөгийн зөрчилд 1309 төлбөрийн акт тогтоож, 148.3 тэрбум төгрөгийн зөрчилд 2834 албан шаардлага, 1.9 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 119 санал хүргүүлж, 101.6 тэрбум төгрөгийн зөрчилд 4413 зөвлөмж өгч, 0.2 тэрбум төгрөгийн 6 асуудлыг хуулийн байгууллагад шилжүүллээ.

Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн өмчит 165 хуулийн этгээдээс Төрийн аудитын байгууллага болон гэрээгээр аудитын хуулийн этгээдүүд 159, Төрийн банк ХХК, Үндэсний давхар даатгал, Хадгаламжийн даатгалын корпорацын санхүүгийн тайланд ТУЗ-ээс сонгосон аудитын хуулийн этгээд аудит гүйцэтгэж нийт 162 санхүүгийн тайланг аудитад хамруулж, үйл ажиллагаа явуулаагүй 3 байгууллага аудитад хамрагдаагүй байна. /Аялал жуулчлалын үндэсний төв ТӨҮГ, Горхи мэлхий хад амралтын газар, Хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, үйлдвэрлэл технологийн нэгдэл ТӨҮГ/

Аудитад хамрагдсан 162 хуулийн этгээдээс 15 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 147 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт өгсөн. /Зөрчилгүй 110, Хязгаарлалттай 32, Сөрөг дүгнэлт 4, Дүгнэлт өгөхөөс татгалзсан 1/

Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 1,995.9 тэрбум төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 644.9 тэрбум төгрөгийн 258 алдааг залруулж, 6.0 тэрбум төгрөгийн зөрчилд 93 төлбөрийн акт тогтоож, 1,239.8 тэрбум төгрөгийн зөрчилд 232 албан шаардлага, 3.6 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 18 санал хүргүүлж, 101.6 тэрбум төгрөгийн зөрчилд 343 зөвлөмж өглөө.

Хүснэгт.№27 Өөрчлөлттэй дүгнэлттэй байгууллагууд

Хязгаарлалттай санал дүгнэлт	
1. Төрийн орон сууцны корпораци ХХК	2. Зүүнбаян төмөр зам ХХК
3. Барилга захиалагчийн ажлын алба ТӨААТҮГ	4. Мон-Атом ХХК
5. Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургууль	6. Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ХХК
7. Иргэний нисэхийн үндэсний төв ТӨААТҮГ	8. Эрдэнэс Метан ХХК
9. ИНЕГ-ын харъяа Ховд аймаг дахь нисэх буудал	10. Эрдэнэс Силвер Ресурс ХХК
11. Монголын төмөр зам ТӨХК	12. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ
13. Эрдэнэссант АЗЗА ТӨХК	14. Хилийн цэргийн 0119 дүгээр анги ТӨААТҮГ
15. Налайх АЗЗА ТӨХК	16. Биокомбинат ТӨҮГ
17. Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ	18. Хөдөө аж ахуйн бирж ХХК
19. Төрийн ордны мэдээлэл, үйлчилгээний	20. Тавантолгой дулаан цахилгаан станц ХХК

цогцолбор ТӨААТҮГ	
21. Буянт-Ухаа спортын ордон ТӨҮГ	22. Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв ТӨҮГ
23. Зээлийн батлан даалтын сан	24. Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ
25. Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	26. Эгийн голын усан цахилгаан станц ХХК
27. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК	28. Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК
29. Монгол кино нэгтгэл ТӨҮГ	30. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК
31. Хөдөө аж ахуйн их сургууль	32. Ди Би Эм Ассет менежмент ҮЦК ХХК
Сөрөг санал дүгнэлт	
1. Аялал жуулчлалын хөгжлийн төв ТӨҮГ	2. Завхан АЗЗА ТӨХК
3. Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨҮГ	4. Эрдэнэс Монгол ХХК
Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
1. ИНЕГ-ын харьяа Сэргээн засах амралт ТӨААТҮГ	

Үйл ажиллагаа нь зогсож, татан буулгах шийдвэр гарсан боловч авлага, өр төлбөрийн үлдэгдэлтэй, хөрөнгийн эзэмшлийн асуудлыг шийдвэрлээгүй зэрэг шалтгаанаар харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн 4 төрийн өмчит хуулийн этгээд байна. Үүнд:

- ХЗДХЯ-ны харьяа Монгол тамга УТҮГ,
- БОАЖЯ-ны харьяа Аялал жуулчлалын үндэсний төв ТӨҮГ,
- ЭМЯ-ны харьяа Био бэлдмэлийн үйлдвэр ТӨҮҮГ,
- БШУЯ-ны харьяа Хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, үйлдвэрлэл технологийн нэгдэл ТӨҮГ.

Аудитын илрүүлэлт:

- Худалдан авах ажиллагааны журам заавар, зөрчиж шууд гэрээ байгуулж бараа, ажил үйлчилгээ худалдан авсан, тендер зарлахаас зайлсхийж, тендерийг хуваж харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан, тендерийн үнэлгээг буруу хийсэн, цахим системээр зарлаагүй зэрэг худалдан авах ажиллагаатай холбоотой 31.4 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн. / ЭХЯ-ны харьяа 6 ТӨХЭ 4.3 тэрбум, УУХЯ-ны харьяа 4 ТӨХЭ 26.1 тэрбум, БОАЖЯ-ын харьяа 1 ТӨХЭ 0.6 тэрбум, БХЯ-ны харьяа 1 ТӨХЭ 0.1 тэрбум, СЯ-ны харьяа 1 ТӨХЭ 0.2 тэрбум төгрөг/
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг хэрэгжүүлэлгүй баталсан зардлыг хэтрүүлсэн, үр ашиггүй зардал гаргасан, албан конторын тавилга болон бусад үндсэн хөрөнгийг худалдан авсан, шагнал, урамшуулал олгосон, хурал, спортын арга хэмжээ зохион байгуулсан, нэвтрүүлэг, сурталчилгаа зэрэгт 10.5 тэрбум төгрөг зарцуулсан. /УУХЯ-ны харьяа 9 ТӨХЭ 8.3 тэрбум, ЭХЯ-ны харьяа 10 ТӨХЭ 1.4 тэрбум, СЯ-ны харьяа 2 ТӨХЭ 0.6 тэрбум, ЗТХЯ-ны харьяа 7, БХБЯ-ны харьяа 2, БОАЖЯ-ны харьяа 1, ЗГХЭГ-ын харьяа 1 ТӨХЭ-ийн 0.2 тэрбум төгрөг/
- Монголын газрын тос боловсруулах ХХК-ийн эзэмшлийн 27 км төмөр замаар 3 аж ахуй нэгж 103,881.3 тонн бүхий 1501 вагон ачаа тээвэрлэсний 1.7 тэрбум төгрөгийн зам ашиглалтын төлбөр аваагүй;
- Шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан нь тогтоогдсон ажилтны ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт олгосон 0.1 тэрбум төгрөгийг буруу шийдвэр гаргасан этгээдээр нөхөн төлүүлээгүй./ ИНЕГ 113.6 сая, Сэлэнгэ АЗЗА ТӨХК 11.3 сая, УБЦТС ТӨХК 26.4 сая /
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ажиллагсдад амьдрах зориулалтаар түрээслүүлдэг орон сууцны мкв-ийн үнийг 683 төгрөгөөр тогтоосон нь өнөөгийн жишгээс хэт бага, төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн жишиг үнэ 4500 төгрөгөөр тооцоход жилд ойролцоогоор 0.6 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэх боломжийг алдсан;
- Зүүнбаян төмөр зам ХХК төмөр замын төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг гүйцэтгэгч Монголын төмөр зам ТӨХК-д шилжүүлэхдээ гүйцэтгэлийн тайланг хянан баталгаажуулаагүйгээс 0.3 тэрбум төгрөгийг илүү шилжүүлсэн.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитад орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой 332 хуулийн этгээдийн санхүүгийн тайланг хамруулахаас 242 хуулийн этгээдийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж /Зөрчилгүй 179, Хязгаарлалттай 52, Сөрөг 5, Санал дүгнэлт гаргахаас татгалзсан 6/, 77 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж, 13 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Аудитаар нийт 123.0 тэрбум төгрөгийн 1187 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 59.2 тэрбум төгрөгийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 360 алдааг залруулж, хууль, тогтоомжийн холбогдох заалтыг зөрчсөн 0.5 тэрбум төгрөгийн зөрчилд 91 төлбөрийн акт тогтоож, 44.7 тэрбум төгрөгийн зөрчилд 261 албан шаардлага, 1.3 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 16 санал хүргүүлж, 17.3 тэрбум төгрөгийн зөрчилд 458 зөвлөмж өгч, 1 зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүллээ.

Аудитын илрүүлэлт:

- Нийслэл дэх ОСНААУГ ОНӨААТҮГ өмнөх оны 1.7 тэрбум төгрөгийн өглөгийг барагдуулахын тулд ХҮТ-12-ны айл, өрх, аж ахуйн нэгжүүдийн хэрэглээний цэвэр, бохир усны заалт болон төлбөрийг нэмэгдүүлэн төрөөс хариуцах хөнгөлөлтөд хамруулж санхүүжилтийг авсан; цахилгаан, дулааны эрчим хүчний төлбөрийг төрөөс хариуцан төлөх хэрэглээг өмнөх оны мөн үеийн хэрэглээтэй жишихгүй тухайн үеийн хэрэглээгээр тооцож 0.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг илүү хамруулсан;
- Худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчиж худалдан авалт хийсэн, хугацаа дуусан барьцааг гүйцэтгэгч байгууллагад буцаан олгоогүй, гэрээний алданги тооцоогүй, гэрээг дүгнээгүй зэрэг 1.2 тэрбум төгрөгийн зөрчил /Улаанбаатар спорт менежмент ХК 0.1 тэрбум, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ 0.1 тэрбум, Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ 0.2 тэрбум, Булган аймаг дахь Илчит Хутаг ОНӨААТҮГ 0.2 тэрбум, Говь-Алтай аймаг дахь Дарив-Эрчим хүч 0.1 тэрбум, Ундарга-Алтай ААТҮГ 0.1 тэрбум, Радио өргөн нэвтрүүлэх станц, Солонго дулааны станц ААТҮГ 0.1 тэрбум, Тавантолгой ХК 0.1 тэрбум, Орхон аймаг дахь Эрдэнэ Ус ДТС ОНӨҮГ 0.2 тэрбум/;
- Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Тохижилт үйлчилгээний алба уул уурхайн компаниас гэрээний төлбөр нэрээр 0.2 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж сумын Засаг даргын захирамжаар 0.1 тэрбум төгрөгийг зарцуулсан;
- Баян-Өлгий аймгийн Жана-Өлке ОНӨААТҮГ-ыг татан буулгахдаа хөрөнгийг ОНӨГ-т шилжүүлсэн ч 0.5 тэрбум төгрөгийн өглөгийн асуудлыг шийдвэрлээгүй;
- Хэнтий аймгийн Орон сууц ОНӨААТҮГ-ын дүрмийн санг 1.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх эх үүсвэрийг орон нутгийн өмнөх оны төсвийн давсан орлогоос бүрдүүлсэн.
- Завхан аймгийн Амь-Ус ХХК-ийн санхүүгийн тайланд олон жил болсон, барагдуулаагүй, 1.3 тэрбум төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй;
- Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот 8 байгууллагын зорилтот түвшний гэрээ байгуулаагүй /Нийслэлийн Төр захиргааны авто бааз, Үртсэн шахмал түлшний үйлдвэр ОНӨААТҮГ, “Багахангай мах боловсруулах үйлдвэр” ОНӨААТҮГ, Олон улсын худалдаа, логистикийн төв ХК, Нийслэлийн Орон сууцны корпорац ХК, Улаанбаатар спорт менежмент ХХК, Улаанбаатар хотын хөгжлийн корпорац ХК, Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК/

Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн тайлангийн аудит

Монгол Улсад гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй нийт 168 /Сангийн сайдын нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг 162, бусад ТЕЗ-дад харьяалагдах 6/ төсөл, хөтөлбөрөөс 57 төслийн санхүүгийн тайланд дүгнэлт өгч /Зөрчилгүй 44, Хязгаарлалттай 12, Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан 1/, төсөл хөтөлбөрийн 44 нэгжийг аудитын түүвэрт хамруулж, 67 төсөл ашиглалт гараагүй тул аудитад хамруулаагүй.

Сангийн сайдын санхүүгийн тайланд нэгтгэгдсэн төсөл, хөтөлбөрийн хувьд тайлант онд гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр 156 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж 1,355.4 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан байна. Гүйцэтгэлээр гадаад зээлээс 78 төсөл, хөтөлбөрт зориулж 1,391.4 тэрбум төгрөгийн ашиглалт гарч, гадаад тусламжийн эх үүсвэрээс 24 төсөл, хөтөлбөрт 155.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдож, 67 төсөлд ашиглалт гараагүй байна.

Гүйцэтгэлээр 115 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өмнөх оны санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл болон тайлант оны санхүүжилтээс 1,341.3 тэрбум төгрөгийн зарцуулалт гарсан байна.

Бусад төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 6 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 13.1 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг гадаадын тусламж, өмнөх оны зарцуулагдаагүй үлдэгдлээс бүрдүүлж, 10.6 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Аудитаар нийт 411.1 тэрбум төгрөгийн 211 алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 31.7 тэрбум төгрөгийн 83 алдааг залруулж, 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 356.2 тэрбум төгрөгийн зөрчилд 35 албан шаардлага, 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 3 санал хүргүүлж, 22.4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 80 зөвлөмж өгч, хуулийн байгууллагад 0.6 тэрбум төгрөгийн 2 зөрчлийг шилжүүлсэн.

Хүснэгт.№28 Өөрчлөлттэй дүгнэлттэй төсөл хөтөлбөрийн нэгж

Хязгаарлалттай санал дүгнэлт	
1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл	2. Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл
3. Боловсролын чанарын шинэчлэл төсөл	4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл
5. Төлбөрийн системийн шинэчлэл төсөл	6. Хөдөө аж ахуй хөдөөгийн төсөл
7. Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл	8. Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл
9. Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилт-2	10. Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл
11. Бүс нутгийн автозам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл	12. Цахим эрүүл мэнд төсөл /Дэлхийн банк/
Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
1. Монгол Улсад ковид 19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах төсөл	

Аудитын илрүүлэлт:

- Хөдөө аж ахуй болон хөдөөгийн хөгжлийн төсөл нэмэлт санхүүжилт төслийн хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтөөс төвлөрсөн 1.9 тэрбум төгрөгийг Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байршуулсан нь эрсдэл үүссэн;
- Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл АХБ-аас зөвшөөрөгдсөн Худалдаа хөгжлийн банкны хадгаламжийн дэд дансанд байршуулсан мөнгөн хөрөнгөөс Төрийн банкны харилцах дансанд 4.0 тэрбум төгрөгийг 2021 оны 12 дугаар сард зөвшөөрөлгүй байршуулсан;
- Төслийн хугацаа дуусаж байгаа боловч төслийн зорилтот үр дүндээ хүрэх боломжгүй болсон /Цахим эрүүл мэнд төсөл, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл/;
- Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл 7700 гаруй га талбайд төслийн хүрээнд бий болох услалтын системийг ирээдүйд эзэмших, засвар үйлчилгээг хариуцах зохицуулалтыг шийдэгдэгүй;
- Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх төслөөс жижиг, дунд үйлдвэрлэлийн санхүүжилтийн хүртээмж нэмэгдсэн байх зорилтын хүрээнд аж ахуй нэгж, иргэдэд гаргасан нийт батлан даалтаас 6.6 тэрбум төгрөг буюу 13.6 хувь нь чанаргүй ангилалд орсон;
- Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх төслөөс 0.5 тэрбум төгрөгийн батлан даалтыг цуцалж, төслийн дэд дансанд буцаахыг АХБ-аас үүрэг болгосон;
- Худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчиж нээлттэй тендер зарлаагүй 1.1 тэрбум төгрөгийн шууд худалдан авалт хийсэн /Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл 0.1 тэрбум, Тогтвортой амьжиргаа 3 төсөл 1.0 тэрбум/.

Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газрын 20 тусгай сангийн санхүүгийн тайлангаас 9 тусгай сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 11 тусгай сангийн санхүүгийн тайланд дүгнэлт өглөө. Үүнд Зөрчилгүй 6, Хязгаарлалттай 4 /Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, Шинжлэх Ухаан, технологийн сан,

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан/ дүгнэлт өгч, Хөдөө аж ахуйг дэмжих санд дүгнэлт өгөхөөс татгалзсан.

Аудитаар нийт 176.4 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 11.9 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 35.0 тэрбум төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 128.4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 25 албан шаардлага хүргүүлж, 1.0 тэрбум төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 14 зөвлөмж хүргүүлжээ.

Аудитын илрүүлэлт:

- Боловсролын зээлийн сан: Өмнөх онд олгогдоогүй гадаад, дотоодын их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж, тэтгэлгийн санхүүжилт 6.0 тэрбум төгрөгийг тайлант оны зардлаар бүртгэсэн, журамд тусгаагүй тэтгэлгийн төрөлд 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон;
- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан: Хэрэгжиж дуусан төсөл, хөтөлбөрийн захиалагчийн хяналтын зардлын үлдэгдэл 0.03 тэрбум төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлээгүй, 0.2 тэрбум төгрөгийн олон жилийн насжилттай авлагын үлдэгдэлтэй, 0.6 тэрбум төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, төсөл, арга хэмжээнд зарцуулах 3.7 тэрбум төгрөгийг хувийн хэвшлийн байгууллагад татаасаар олгосон;
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан: Төсвийн орлогыг 19.6 тэрбум төгрөгөөр тасалсан, найдваргүй авлагын үлдэгдэл 107.4 тэрбум төгрөг, 0.5 тэрбум төгрөгийн зээлийг программд зөрүүтэй бүртгэсэн;
- Кино урлагийг дэмжих сан: Тус сангийн хөрөнгийг зарцуулах журмыг эрх бүхий байгууллагаар батлуулаагүй, эрх зүйн орчин бүрдээгүйгээс зарцуулаагүй 2 жил болсон 10.0 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан: Авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, эргэн төлөлтийн хугацаа дуусан нийт 15.4 тэрбум төгрөг авлагын үлдэгдэлтэй;
- Шинжлэх, ухаан технологийн сан: Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн 0.2 тэрбум төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, урьдчилж гарсан зардалд бүртгэлтэй 4.6 тэрбум төгрөгийн 127 төслийн үр дүнг хэлэлцээгүй;
- Эрүүл мэндийг дэмжих сан: Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журамд заасантай нийцэхгүй төсөлд 0.1 тэрбум төгрөг олгосон, 0.1 тэрбум төгрөгийн гэрээний үүргийн биелэлт хангалтгүй;
- Ирээдүйн өв сан: Ирээдүйн өв санд төвлөрүүлэх 35.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлогыг төвлөрүүлээгүй;
- Төсвийн тогтворжуулалтын сан: Тогтворжуулалтын сан болон Ирээдүйн өв санд төвлөрүүлэх орлогын эх үүсвэрийг хуулийн дагуу сар бүр шилжүүлээгүй;
- Хөдөө аж ахуйг дэмжих сан: Санхүүгийн тайлан иж бүрэн бус, санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл баталгаажаагүй, төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгийн дагуу тайлагнаж ирүүлээгүй, авлага, өглөгийн дансны үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, нягтлан бодох бүртгэлийн программын мэдээллүүд дутуу, зээлдэгчийн овог, нэр, регистрийн дугаар, зээлийн дүн зөрүүтэй, эзэн холбогдогч тодорхойгүй тул анхан шатны баримттай тулган баталгаажуулах боломжгүй тул "Дүгнэлт өгөхөөс татгалзсан" байна.

4.13 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ, ЗАЛРУУЛГА

Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах залруулгыг хийлээ.Үүнд:

- Ханшийн зөрүү 3.8 тэрбум төгрөгийн тэгшитгэлийг хийгээгүй;
- Олон улсын хөрөнгө оруулалтын банкны дүрмийн санд 2021 онд нэмэгдүүлсэн 0.7 сая евро буюу 2.3 тэрбум төгрөгийг зардлаар бүртгэн тайлагнаж, урт хугацаат хөрөнгө оруулалтаар бүртгээгүй;
- Олон улсын валютын сангийн 229.5 сая зээлжих тусгай эрхтэй тэнцэх урт хугацаат зээлийн валютын ханшийн өөрчлөлтийг тооцоолоогүй, 26.8 тэрбум төгрөгөөр илүү илэрхийлсэн.

4.14 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулахаар Монгол Улсын Ерөнхий сайдад 5, Сангийн сайдад 5 зөвлөмж өгснөөс хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд 60.0 хувийн биелэлттэй байна.

- Монгол Улсын Ерөнхий сайдад өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа, 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй,
- Сангийн сайдад өгсөн 2 зөвлөмж хэрэгжиж, 2 зөвлөмж хэрэгжих шатандаа, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.15 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын секторын дотоод аудитын бүтэц, орон тоог 2021 оны байдлаар авч үзэхэд нийт 57 төсвийн ерөнхийлөн захирагчдаас 54 нь дотоод аудитын нэгжтэй бөгөөд 546 албан хаагчидтай, үүнээс 314 дотоод аудитор ажиллаж байна.

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгжийг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах, дотоод аудит, санхүүгийн шалгалт хийх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, чанарын баталгаажуулалт хийх, сургалт зохион байгуулах, хэрэглэгчийг зөвлөгөө, мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчдын дэргэдэх дотоод аудитын нэгжүүд нийт 2279 хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн байна. Шалгалтаар нийт 230.5 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж 2112 акт, 750 албан шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажиллажээ.

5. АУДИТЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

5.1 АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Олон улсын зах зээлд “Сенчири-2027”, “Сенчири-2031” бондыг 2,849.2 тэрбум төгрөгөөр арилжаалж, “Чингис” бондын 1,887.4 тэрбум, “Гэрэгэ” бондын 760.5 тэрбум, нийт 2,647.9 тэрбум төгрөгийн төлбөрийг хугацаанаас нь өмнө төлж, өрийн үйлчилгээний зардлын төсөвт үзүүлэх ачааллыг бууруулан, урт хугацаанд жигдлэх, өрийн багцын эргэн төлөлтийн дундаж хугацааг уртасгасан байна.

2. Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Чингис хаан банканд байршиж буй 264.3 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөд эрсдэл үүссэн байна.

3. Гадаад зээлийн хөрөнгийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт зогссон, эзэн холбогдогч тодорхойгүй, олон жил болсон 533.9 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна.

4. Дамжуулан зээлийн 234.8 тэрбум төгрөгийн хүүг тооцож, хүүгийн авлагыг тайлагнаагүйгээс санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлага, хүүгийн орлого дутуу илэрхийлэгдсэн байна.

5. Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн олгосон зээлийн үлдэгдлээс 56.0 хувь буюу 1,793.9 тэрбум төгрөг чанаргүй зээлийн ангилалд орсон нь гадаад өр төлбөрийг барагдуулах эх үүсвэр дутагдах, Засгийн газарт болзошгүй өр төлбөр үүсэх эрсдэл байна.

6. “Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл”-ийн хүрээнд дамжуулан зээлдүүлсэн 200.8 тэрбум, Налайх-Чойр чиглэлийн 220 км авто зам, Дархан-Эрдэнэт чиглэлийн авто замын төслийг хэрэгжүүлэхэд зарцуулсан дамжуулан зээлийн 101.2 тэрбум төгрөгийг холбогдох байгууллагуудын санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгээгүй, зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

7. Гадаад, дотоод зээлийн эх үүсвэрээс болон Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөс иргэн, хуулийн этгээдэд олгосон зээлийн нэгдсэн мэдээллийн сан үүсгээгүйгээс зээл олголт, эргэн төлөлтөд тавих хяналт хангалтгүй, хяналтын болон хариуцлагын тогтолцоо бүрдээгүй, хугацаа хэтэрсэн найдваргүй зээлийн авлага барагдахгүй, жил бүр нэмэгдсээр байна.

8. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газрууд нийт дүнгээр 1,147.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан боловч, төрийн өмчит 67 хуулийн этгээдийн санхүүгийн үр дүн 367.7 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

9. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухайн жилийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийг нэгтгэж, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд илэрхийлээгүй байна.

10. Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байгууллагуудын цэвэр хөрөнгө/ өмчийг бүрэлдэхүүний өөрчлөлт, тохируулгыг бүрэн тодруулаагүй байна.

11. Засгийн газрын урт хугацаат үнэт цаас, зээлийн үлдэгдэл нийт өр төлбөрийн 84.7 хувь буюу 38,259.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

12. Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийн биелэлт 88.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

13. Төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагааг зохицуулсан хууль, эрх зүйн орчингүй, бүтэц, орон тоо, тогтолцоо оновчтой бус, үйл ажиллагаа хангалтгүйгээс

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАГДМАЛ ТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

санхүүгийн тайлангийн аудитаар илэрч буй алдаа, зөрчил буурахгүй, өгсөн зөвлөмж, тогтоосон акт, хүргүүлсэн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

5.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

Улсын секторын дотоод аудитын харилцааг зохицуулсан эрх зүйн орчинг буй болгож, хяналтын тогтолцоог сайжруулахыг уламжилж байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД-д:

1. Гадаад, дотоод зээлийн эх үүсвэрээс болон Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөс иргэн, хуулийн этгээдэд олгосон зээлийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, эрсдэлтэй авлагыг барагдуулах ажлыг Засгийн газрын түвшинд зохион байгуулан, хяналт тавих.

2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухайн жилийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийн нэгтгэл тайланг гарган Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хавсралтаар толилуулж тайлагнах, үйл ажиллагааны үр дүнд тавих хяналтыг сайжруулах.

3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн дамжуулан зээлийн өр төлбөрийг барагдуулах талаар эдийн засгийн зорилтот түвшин болон гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд тусгуулах арга хэмжээ авахыг холбогдох байгууллагуудад чиглэл өгч, шийдвэрлэх.

4. Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуурыг хангахгүй байгаа арилжааны банканд байршиж буй эрсдэлд орсон мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлэх талаар холбогдох байгууллагад чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах.

5. Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-аас олгосон “чанаргүй” ангилалд орсон, эргэн төлөлт хийгдэхгүй байгаа зээлийг хууль, хяналтын байгууллагатай хамтран төлүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, болзошгүй өр төлбөр үүсэх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авах.

6. Төрийн аудитын байгууллагаас аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Төсвийн ерөнхийлөн захирагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтэд хяналт тавих.

САНГИЙН САЙД-д:

1. “Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл”-ийн хүрээнд дамжуулан зээлдүүлсэн 200.8 тэрбум, Налайх-Чойр чиглэлийн 220 км авто зам, Дархан-Эрдэнэт чиглэлийн авто замын төслийг хэрэгжүүлэхэд зарцуулсан дамжуулан зээлийн 101.2 тэрбум төгрөгийн өр төлбөрийг холбогдох байгууллагуудын санхүүгийн тайланд тусгуулах.

2. Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байгууллагуудын цэвэр хөрөнгө/ өмчийг бүрэлдэхүүний өөрчлөлт, тохируулгыг бүрэн тодруулж байх.

3. Ирээдүйн өв сангийн мөнгөн хуримтлалыг Монголбанкан дахь харилцах дансанд байршуулах арга хэмжээг 2025 он хүртэл үе шаттайгаар авч хэрэгжүүлэх.

4. Дамжуулан зээлийн хүүгийн авлагыг бүртгэлд тусгаж, тайлагнах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 08 өдөр Дугаар А/46 Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан"-г хавсралт ёсоор баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд тус тус хүргүүлэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар (Б.Бундхорол), Аудитын хоёрдугаар газар (Ц.Наранчимэг)-т тус тус даалгасугай.

3. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Л.Оюун-Эрдэнэ), Сангийн сайд (Б.Жавхлан) нарт тус тус зөвлөсүгэй.

4. Монгол Улсын Их Хурал болон холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, аудитын үр дүнд хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Сарансүх)-д үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ

Z:\Tushaal\2022\EA-Ын А Тушаал\0608 Auditin 2 Gazar - 2.Docx

0001013135

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Монгол Улс, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: +976 51-261585. Факс: +976 11-323266, 11-324853
И-мэйл: info@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn